

Даниел Дефо

# РОБИНЗОН КРУЗО



# Робинзон Крузогийн адал явлууд

Даниел Дефо, 1719 он

## 1-р бүлэг

# Робинзоны эхэн үеийн аяллууд

“Робинзон, хэрвээ чи далайд гарвал амьдрал чинь зовлон болох болно. Чи үүндээ харамсах болно!” гэж ноён Крузо хэлэв.

Гэвч арван найман настай Робинзон Крузо аавынхаа үгийг, тэр хөгшин хүний нулимсыг үзээд санаагаа өөрчилсөнгүй. Түүний амьдралдаа хүссэн цорын ганц зүйл нь далайд гарч өөрийн аз хийморийг сорьж үзэх байлаа. Тэр аавынхаа итгэж байснаар хууль судлахыг хүссэнгүй. Мөн ээжийнхээ итгэж байснаар гэр бүлийнхээ амжилттай бизнесийг өвлөж авахыг хүссэнгүй.

“Ганцхан аялал, тэгээд тэр надад таалагдахгүй бол би эргэж ирээд Йоркшайрт гэр бүлийнхэнтэйгээ хамт амьдрах болно” гэж Робинзон мэтгэв.

Гэвч ноён, хатагтай Крузо нар түүнийг нь зөвшөөрөхгүй байлаа. Далайчны амьдрал их аюултай байлаа. Хар салхи далайд байнга үүсдэг байлаа. Хар салхи ихэнхдээ хөлгийг чиглэлээс нь төөрүүлж орхиод бүр хадан эрэгт цохиж хэдэн хэсэг болгон буталдаг байлаа. Дээр нь бас худалдаачны онгоц руу довтолж, ачаа барааг нь хулгайлаад багийн хүмүүсийг нь алах далайн дээрэмчид байдаг байлаа. Үгүй, гэж ноён, хатагтай Крузо нар шийдээд зөвшөөрөл өгч хүүгийнхээ сүйрлийг бүтээлцэж чадахгүй гэж хэлжээ.

Тиймээс дахиад нэг жил Робинзон далайн тухай мөрөөдөхөөс өөрийг хийж чадахгүй үлджээ. Нэг өдөр тэрээр Халлийн тэнгисийн боомтод байдаг найз дээрээ зочилж очжээ. Тэр хүүгийн аав, далайн ахмад Английн эргийг уруудаад Лондон орох богино аялалд гарах гэж байгааг Робинзон олж мэджээ. Хөлгийн тавцан дээр гарч ахмадын зочны хувиар аялалд гарах урилгыг Робинзон татгалзахын аргагүй байлаа.

Тиймээс есдүгээр сарын нэгний өдөр, 1951 онд Робинзон Крузо Африк, Өмнөд Америк, Английн хөрсөн дээр эргэж ирэх хүртлээ аялах Карибийн тэнгисийн арал хүртэлх олон олон аяллынхаа эхний аяллыг ингэж эхлүүлжээ.

Эхний аялалдаа хөлөг онгоц нь хар салхинд нэрвэгдэх үед Робинзон далайн өвчинд хүндээр нэрвэгдэх ямар байдгийг ойлгож авчээ. Тэр далайн хар салхи хичнээн ширүүн, сүйрэл дагуулсан байдаг гэдгийг, мөн догшин давалгаа, хүчит салхины мэдэлд байх ямар байдгийг сурч авчээ.

Гэхдээ тэр бүх айдас, далайн өвчин Робинзоныг аврагдаж хуурай газар дээр нэгэнтэй эргэн ирсний дараа удалгүй алга болсон байна. Түүний дараахан, тэрээр хоёрдахь аялалдаа гарчээ. Энэ удаа тэр Африкийн эрэг рүү хөдөлсөн байна. Тэр нутгийн хүмүүстэй хэрхэн амжилттай худалдаа хийхийг сурсан байна. Тэр мөн далайн дээрэмчдийн бүлэгт довтуулж, баригдахын айдсыг сурсан байна. Тэр далайн дээрэмчдийн ахлагчийн боол байж амьдрахын зовлон болоод ахмадын жижиг загасны завиар зугтаахын баяр хөөрийг мөн мэдэрчээ. Робинзон эцэст нь Өмнөд Америкийн Бразил руу чиглэж явсан Португалийн худалдаачны хөлөг онгоцтой таарч аврагджээ. Бразилд Робинзон чихрийн тариаланд ажиллахаар болж, хэдэн жилийн дараа өөрийн гэсэн тариалан худалдаж авчээ. Тэр өөрийн тариалангаа хэдэн жилийн турш амжилттай явуулж байсан бөгөөд бусад тариаланчдын дунд олон найзтай болжээ.


Тариаланчид тариалангаа явуулахын тулд нэмэлт тусlamж хэрэгтэй байгааг ойлгох үед тэд Робинзонос Африк руу явж боол худалдаж авч ирж өгч чадах эсэхийг нь асуужээ. Африкийн угуулууд маш сайн, үнэнч ажилчид болдог байжээ. Түүнээс гадна, Робинзон өмнө нь Африкт байж үзсэн байсан бөгөөд угуул иргэдтэй хэрхэн худалдаа хийхийг мэддэг байсан юм.

Гэхдээ тэр өөрөө олон жилийн турш амжилттайгаар явуулсан тариалантай байсан юм. Одоо түүнийгээ орхиод Атлантын далайн хөндлөн гулд тийм аюултай аялалд гарах нь тэнэг, эсвэл галзуу санагдаж байлаа.

Гэвч өөр нэгэн далайн аяллын санаа Робинзоныг ихэд догдлуулж тэрээр явахыг зөвшөөрчээ.

Бусад тариаланчид Робинзоны тариаланг харж хандахаа амлаад хэрвээ тэр эргэж ирэхгүй бол гэрээслэлийнх нь дагуу бүхнийг хийх болно гэдгээ бас амлажээ.

Тэгээд, есдүгээр сарын нэгэнд, 1659 онд Английн Халлд анх хөлгийн тавцан дээр гарснаасаа есөн жилийн дараа Робинзон Крузо Бразилийн Сан Сальвадороос аялалд гарчээ. Энэ аялал түүний болоод ямар ч хүний амьдралын хувьд хамгийн агуу аялал болох байлаа.



## 2-р бүлэг

# Хөлөг онгоцны сүйрэл!

Есдүгээр сарын тэр нэгэн нарлаг өглөө Сао Сальвадороос хөдөлсөн хөлөг онгоцны тавцан дээр хөлгийн ахмад, арван хоёр далайчин болон Робинзон Крузо гэсэн арван дөрвөн хүн байсан юм. Тэрээр ачаа болгож Робинзоны нутгийн хүмүүст худалдаалахаар төлөвлөөд байсан тоглоомуудыг авч гарсан юм. Эдгээр тоглоомууд нь шүр сувд, хясаа, хутга, хайч, жижиг сүх болон жижиг толинууд байсан юм.

Хөлгийн ахмад хөлөг онгоцоо Бразилын эргийн дагуу хойд зүг рүү залж байлаа. Дараагаар нь тэр зүүн зүг чиглэн Атлантын далайг туулж Африкт очиhoор төлөвлөж байсан юм.

Тэнгис дэхь хорь дахь өдрөө тэд Өмнөд Африкийн хойд хошуунд дөхөж явахдаа ширүүн хар салхинд нэрвэгджээ. Арван өдөр дараалан догшин салхи хөлөг онгоцыг зүг бүрт түлхэж байлаа. Хоёр хүн хөлгийн тавцангас унаж, нэг хүн халуун орны чичрэгээр өөд болжээ. Хором бүрт Робинзон тэнгист залгигдана гэж бодож байлаа. Далбаа урагдаж, шураг эвдэрч хөлөг онгоц хэд хэдэн газраараа цоorskон байлаа.

Арван нэг дэхь өдөр салхи намжиж ирэх үед Робинзон хөлгийн ахмад хоёр хөлөг онгоцонд учирсан эвдрэлийг шалгаж үзжээ. Тэд хөлөг онгоц Африк руу аяллаа үргэлжлүүлэх ямар ч нөхцөлгүй болсон гэдэг дээр санал нэгдсэн юм. Хөлгийн ахмад Бразил руу буцахыг хүссэн боловч Робинзон санаа нэгдсэнгүй. Тэд аль хэдийнээ хойд зүтг их хол явчихсан байсан тул Карибын тэнгисийн Британий арлуудын нэг рүү чиглэх нь илүү ойр байлаа. Барбадосын арал арван тавхан өдрийн зйттай байсан юм. Тэд тэнд хөлөг онгоцоо засч болох байсан юм.

Гэвч хоёр дахь салхи нэрвэж тэднийг дахин чиглэлээс нь гаргалаа. Хүчит урсгал тэднийг зүүн зүтг бүдүүлэг зэрлэгүүдийн суурьшсан газрын зүг түрж байлаа.

Хөлөг онгоц бүхэл шөнийн турш салхи болон тэнгист балбуулж байсан юм. Үүр цайх үед “Газар! Газар!” гэж орилолдох дуунаар Робинзон сэрээд тавцан дээр гарч хаашаа зааж байсныг нь харжээ.

Гэвч тэр мөчид хөлөг онгоц хадан эрэг мөргөж үхсэн юм шиг зогтусав. Тэнгис эвдэрхий хөлгийг бүх хүчээрээ балбасаар л байлаа. Салхи бүр ширүүсэхэд Робинзон хөлөг сүйрэх хүртлээ хичнээн их шийтгэл амсах юм бол гэж гайхаж байлаа. Одоо хөлгийг орхихоос өөр сонголт үлдээгүй учир хөлгийн ахмад тушаалаа буулгажээ.

Багийнхан авч явсан аврах завиа тэр даруй буулгаж хүн бүр сууцгаав. Салхи бага зэрэг намжсан ч тэнгис өндөрөөс өндөрт давалгаалсаар л байлаа.

Аврах завь ямар ч далбаагүй байсан тул эрчүүд бүх хүчээрээ сэлүүлдэж байлаа. Гэвч тэд зэрлэг тэнгисийн мэдэлд байсан юм.

Гэнэт гучин фут илүү өндөр догшин давалгаа тэдэн дээр ирлээ. Арван нэгэн залуугийн хувьд тэр давалгаа завийг эргүүлж тэднийг залгихаас өмнө амьсгаа авах ч цаг байсангүй.

Гэхдээ Робинзон усанд сайн сэлдэг байсан тул ширүүн давалгааны хүчтэй тулалдсангүй. Тэр гадаргуугаас доош живж өөрийн бараг л амьгүй болсон биеэ давалгаанд даатгаж түүний хүссэн зүгт явж байлаа.

Давалгаа түүнийг эргийн зүг урсгаж ус залгиж хагас үхдэл болсон түүнийг хагас замд орхижээ. Тэр хоёрдахь давалгаа ирэхээс урьтаж хөлөөрөө тэнгисийн ёроолд хүрэх гэж оролдсон боловч хүрэхээсээ өмнө тэр дахиад гучин фут усанд булшлагдаж эргийн зүг алгуурхан хөвжээ. Энэ удаад харин Робинзон амьсгалаа түгжиж амжжээ.

Ушиг нь яг дэлбэрэх гэж байгаа юм шиг мэдрэгдэх үед түүний толгой гар нь усны мандлаас дээш гарч ирэв.

Тэнгисийн татлага түүнийг буцаан сорохоор оролдох үед Робинзон хөлөө элсэнд шигтгэв. Гэвч тэнгис түүнийг хараахан зүгээр орхиогүй байлаа. Дахиад хоёр удаа тэр давалгаанд өргөгдөж урсав. Сүүлийн давалгаа түүнийг биенийх нь бүх агаар цохигдож гарахаар тийм их хүчээр том чулуунд цохиж гэнэ.

Эцсийн хүчээ шавхаж Робинзон хөл дээрээ босч эргийн зүг гүйв. Тэнд зэрлэг давалгаа хүрэхгүй газар очоод элсэн дээр унаад өгөв гэнэ.

Гэдэснээсээ давстай усыг бөөлжиж гаргаад тэр тэнд хэвтэж агаар амьсгалж хэвийн амьсгалаа эргүүлэн олж авахыг оролдож байлаа. Түүний хүч чадал аажимдаа ирэх үед Робинзон амийг нь аварсанд бурханд талархаж залбирав гэнэ. Түүний багийн хүн бүр живсэн байхад түүний амь аврагджээ.

Тэр босч суугаад эрэг дээр шидэгдсэн хөлгийнхөө зүг харуулдаж байлаа. Хөлөг их хол харагдаж, тэр яаж эрэг хүртэл ирж чадсандаа гайхширч байлаа.

Тэрээр босч эргэн тойрноо харж чадахуйц хүчтэй болох үедээ Робинзоны баяр баясал гуниг болж өөрчлөгдөв. Тэр энд ганцаараа байжээ. Гэхдээ энд гэж хаана вэ? Түүнд идэх, уух юу ч байсангүй. Тэр өлсөж үхэх юм гэж үү? Эсвэл тэр ямар нэгэн зэрлэг араатанд бариулж идүүлэх юм гэж үү? Түүнд ан хийх, эсвэл өөрийгөө хамгаалах зэвсэг гэхээр зүйл бүсэнд нь байсан жижиг хутганаас өөр байхгүй байлаа.

Эдгээр айдас түүнийг их хурдан нөмөрч тэр эргийн дагуу цээжээ дэлдэн, “Та намайг энэ зовлонд унагах байсан юм бол яагаад аварсан юм бэ?” гэж бурхан руу хашширч яг л галзуу хүн шиг гүйж байлаа.

Гүйх, хашхирах ямар ч тэнхэлгүй болсныхоо дараа Робинзон элсэн дээр сууж бодлоо цэгцлэхийг оролдож байлаа. Шөнө болох дөхөж байлаа. Гэвч гэрэл бүрмөсөн алга болохоос өмнө тэр уух цэвэр ус олох хэрэгтэй байлаа. Тэгээд тэр арлаар бага зэрэг явж цэвэр хүйтэн устай жижиг горхи олжээ.

Дараагаар нь тэр шөнийг өнгөрүүлэх газар – зэрлэг амьтны дайралтаас хамгаалагдаж болох газар олох хэрэгтэй байлаа. Тэр том, бүдүүн, гацуур шиг мод олсон бөгөөд авирч гарав. Хоёр том мөчир дээр гарч тухалсны дараа түүний толгой маргааш ямар үхлээр үхэх бол гэсэн бодлоор дүүрч эхлэв.

Гэхдээ энэ бүх бодол түүнийг эргүүлж байсан ч Робинзон маш их ядарсан байсан тул удалгүй нам унтжээ.



## 3-р бүлэг

# Шинэ амьдрал эхлүүлсэн нь

Дараах өглөө нь Робинзоныг сэрэхэд цаг агаар цэлмэг болсон байлаа. Салхи өнгөрсөн байлаа. Тэр модны өтгөн мөчрийг хажуу тийш нь болгож дөлгөөн тэнгисийн зүг харав. Хөлөг онгоц нь шөнө хадан цохионоос гарч давалгаанд түрэгдсээр эрэг рүү ойртох ирсэн байгааг хараад тэр гайхав. Тэр одоо эрэгтэй хагас миль ч хүрэхгүй ойртох ирээд хаданд тулж зогссон байлаа.

“Ямар гунигтай юм бэ! Манай хүмүүс хөлгийн тавцан дээрээ байж байсан бол тэд одоо амьд байж болох байлаа” гэж Робинзон уйлав. Гэвч Робинзоны нулимын одоо тэдэнд тусалж чадахгүй билээ. Тэд ч бас түүнд тусалж чадахгүй билээ. Тэр хөлөг онгоц руу очиж арал дээр түүнд хэрэг болж болох бүгдийг авах хэрэгтэй байлаа.

Үд дунд болоход давалгаа холдож тэнгис их гүехэн болсон тул Робинзон хөлөг рүү хялбархан сэлээд очихов. Тэр тавцангасаа унжиж байсан олсноос барьж аван тавцан руу авирч гараад хайгуулаа эхэллээ.

Түүний аз болоход хөлгийн бүх хоол хуурай, давстай ус хүрээгүй байлаа. Тэр өчигдрөөс хойш юу ч идээгүй учир, Робинзон амаа дүүргэж өхлээд дараа нь халаасаа жигнэмэгээр дүүргэв. Гэхдээ хоол хүнснээс өөр авч явах зүйл маш их байсан тул тэр бүгдийг эрэг дээр гаргахад түүнд завь хэрэгтэй байлаа.

Робинзон сайн сал хийж болохоор хэдэн хөлөг онгоцны шураг олжээ. Тус бүрийг нь олсоор холбоод хажуу тийш нь тэнгис рүү шиджээ. Тэр шургуудыг урсгаад явуулчихгүй тулд олснуудын үзүүрийг барьж байсан юм.

Дараагаар нь тэр өөрөө доош буугаад шургуудыг бэхэлж эхлэв.

Хэдэн цагийн дараа Робинзон салаа ачаалж эхлэх боломжтой болжээ. Эхлээд тэр олсон бүх сул халтангуудаа давхарлаж овоолоод дээр нь далайчны хоосон авдар тавиад талх, будаа, бяслаг, хатаасан мах, эрдэнэшиш, хэдэн лонх ром дарсаар дүүргэжээ. Тэр эдгээр хоол хүнсээ өөртөө зориулж авсан хэдэн илүү хувцасаараа хүчжээ. Учир нь түүний хувцас нь одоо тэнгист цохигдоод салбарсан байсан юм.

Дараа нь тэр эрэг дээр ашиглаж болох багаж хэрэгслийд рүү анхаарлаа хандуулж хөрөө, сүх, алх зэргээр дүүрэн мужааны авдар олоод мөн доош сал руугаа буулгав.

Гэхдээ тэр хоол олохын тулд ан хийх болвол, эсвэл өөрийгөө хүн, амьтны эсрэг хамгаалахаар болох үед түүнд зэвсэг хэрэгсэл бас хэрэгтэй байсан юм. Тэр хэдэн бялттай буу, гурван алтан шувууны буу, хоёр гар буу, хуучин зэвэрсэн сэлэм олжээ. Нэг торх дарь, нэг цүнх сум мөн авав.

Бүх зүйлээ сал дээр ачиж дуусахад давалгаа өндөрсөж эргийн зүг чиглэсэн байлаа. Давалгаа салхитай нийлээд түүнийг ширүүн урсгалд оруулсныг тэр мэдэв. Тэр анх усанд орсон газраасаа өөр зүгт яваад байжээ.

Робинзон ийм урсгал ихэвчлэн далайн булан, эсвэл голын цутгалангийн ойролцоо үүсдэг гэдгийг мэддэг байжээ. Хэрвээ тийм бол тэр салаа голын цутгалангийн дэргэд газардуулсан нь эрэг рүү сэлүүрдэхээс илүү амар байх байлаа.

Робинзон гүнзгий голын цутгаланг олж тэр урсгал нь салыг өөр лүүгээ татаж байгааг олж үзээд их баяртай байлаа. Тэгээд жаахан явж байтал эрэг дээр жижиг тохой байгааг тэр олжээ. Энэ үнэхээр төгс байлаа! Салыг эрэгт хүргэхэд хангалттай гүн, бас тэнгистэй их ойрхон учир Робинзонд зөрж өнгөрөх завийг харахад хангалттай ойр байсан юм.

Эрэгт гараад салаа модтой сайтар бэхлэн уяд Робинзон өндөр уулын зүг хөдлөв. Оройд нь гарвал тэр өөрийн орчин тойрны газраа сайн харж чадна гэж итгэж байлаа. Энэ арал байсан гэж үү? Эсвэл эх газрын эрэг үү? Түүнд мэдэх ямар ч арга байсангүй.

Робинзон уулын оройд авирч гараад түүнийг бүх талаас нь тэнгис хүрээлж байгааг олж мэджээ. Тэр арал дээр ирсэн байлаа, мөн түүний нүд харах зайнд ямар ч газар харагдахгүй байлаа.

Тиймээс тэр голын цутгалангийн эрэг рүү буцаж салан дээрээ тавьсан хавтангуудаар өөртөө овоохой барьжээ. Тэгээд дотор нь орж хэвтэж амрав гэнэ.

Гэвч Робинзон зүгээр амрахад бэлэн биш байлаа. Тэр төлөвлөгөө гаргаж дараа нь юу хийхээ шийдэх хэрэгтэй байв. Эхлээд тэр хөлөг рүү буцан очиж өөр хэрэгтэй зүйлсийг авч ирэх ёстай байлаа. Мөн тэр үүнийг хурдан хийх хэрэгтэй байсан юм. Учир нь дахиад нэг хар салхи болвол хөлөг онгоц хялбархан хэсэг хэсэг болж бутрахаар байсан юм. Тэгвэл бүгд байхгүй болно.

Тиймээс Робинзон арал дээр ямар нэгэн зүйл хийж эхлэхээсээ өмнө хөлөг онгоц руу аль болох олон очиж түүнд хэрэг болж болохоор бүх зүйлийг авч ирэхээр шийджээ.

Өдөр бүр, гурван долоо хоногийн турш, Робинзон хөлөг рүү очиж байлаа. Тэр шуудай шуудайгаар нь хадаас, жижиг сүх, царил, хайч, хутга, сэрээ болон багажуудаа хурцлах чулуу авч иржээ. Тэр мөн луужин, газрын зураг, дуран, олон хувцас, хөнжил, далаа, олс, зотон даавуу, бүр хэдэн алт мөнгөн зооснууд авч иржээ. Дараагаар тэр өөртөө дөрвөн хамтрагчийг элсүүлсэн юм: хөлөг онгоцны нохой, хоёр муур, мөн Библь.

Дөрөв дэхь долоо хоног догшин шуургатай шөнөөр эхэлжээ. Дараа өглөө нь Робинзон тэнгис рүү харуулдахад хөлөг онгоц хаана ч харагдахгүй байлаа. Хагарсан хэлтэрхийнүүд л давалгаагаар ирж байжээ.

Одоо тэр эрэг дээр байрлаж гэр болгох газар хайж эхэлсэн юм. Тэр газар нь цэвэр устай ойр байх ёстай бөгөөд нарнаас бага зэрэг сүүдэрлэгдсэн, хүн болоод зэрлэг амьтдаас хамгаалагдсан, мөн тэнгис сайн харагддаг байх ёстай байлаа. Учир нь Робинзон зөрж өнгөрөх хөлөг онгоц түүнийг аварна гэж найдсаар байсан юм.

Тэгээд Робинзон эрлээ эхлүүлжээ. Өдөр хоногууд өнгөрөхөд тэр арал дээр өнгөрүүлж байгаа цаг хугацаагаа ямар нэгэн аргаар тэмдэглэх хэрэгтэй гэж бодов. Түүнд ямар ч цаас, бал, бэх байгаагүй учир тэр нэг том шонг эргийн ойролцоо суулгаад өдөр бүр нэг ховил татаж байхаар болжээ. Долоо хоног бүр тэр зургаан ховилоо дайруулан арай урт ховил татаж долоо хоногийг тэмдэглэж, тэгээд сар, мөн жилийг тэмдэглэх болжээ.







## 4-р бүлэг

# Робинзон олон чадварт суралцсан нь

Робинзоны гэрээ барих газар хайх эрэл нь уулын дэргэд жижигхэн хавтгай газар олсноор дууссан юм. Тэнд мөн уулын хажууд агуин эхлэл мэт харагдах элэгдсэн цэг харагдаж байлаа. Робинзон тэр цэгийн өмнө уулын хажууд хавтгай газар дээр суурьшихаар шийджээ.

Тэрээр хөлөг онгоцноос авсан далбааныхаа заримыг нь ашиглаж майхнаа босгов. Тэгээд хамгаалалт болгож тэр майхнаа тойруулаад цайз босгожээ. Цайзаа Робинзон цавчиж унагаад үзүүрийг нь хурцалж бэлдсэн залуу моддоор хийв. Хурцалсан үзүүрийг нь дээшээ харуулан майхнаа хагас тойруулан газар суулгажээ. Тэгээд түүний цайз нь нэг талдаа өндөр уултай нөгөө талдаа майхан болоод эд хогшлыг нь хадгалсан модон хашлагатай болжээ. Цайз руугаа орохын тулд тэрээр шат барьсан бөгөөд орсныхоо дараа татаж авах зориулалттай болгожээ.

Цайзаа барьж дуусгаад Робинзон уулын хажуугийн шороо чулууг ухаж өөртөө агуй хийж эхэлжээ. Нар борооноос хамгаалагдах, өөрийн хоол хүнсээ хадгалах сэргүүн хуурай газар түүнд хэрэгтэй байлаа.

Гэрээ тохижуулж байхдаа ч Робинзон өдөр бүр гадагш гарч хоол хүнс олохын тулд анх хийхээр болжээ. Тэр арал дээр олон галуу, тагтаа, ямаа, яст мэлхий олжээ. Тэдний мах, мөн ямааны сүү, яст мэлхийн өндөг нь Робинзоны хоол хүнсний хангамж болж байлаа. Мах нь идэхэд тохиромжтой биш амьтан агнахдаа тэр арьсыг нь авч хатаагаад хувцас эсвэл нөмрөг хийхэд ашиглаж байлаа.

Робинзоны гэр одоо тавилга тавьж тохижуулахад бэлэн болжээ. Гэвч амьдралдаа хэзээ ч багаж барьж байгаагүй хүн хэрхэн ажиллаж чадна гэж итгэх билээ? Робинзон тийм ч итгэлтэй байгаагүй ч олон сарын турш сүх, хөрөөгөөрөө тэвчээртэй ажиллажээ. Эхлээд түүний хийсэн бүх зүйл нь салж унаад байжээ. Гэхдээ эцэст нь тэр өөртөө ширээ сандал хийж чадахаар чадвартай болсон бөгөөд мөн агуйдаа тавиур хийж байрлуулжээ.

Робинзон амжилттай мужаан болсныхоо дараа өөрийн гарыг фермийн ажилд сорьж үзэхээр шийджээ. Түүнд хөлөг онгоцноос авсан эрдэнэшишийн үр байсан юм. Энэ нь түүний анхны ургац болох байлаа.

Тэрээр ухаж, хагалах цэвэр газар олжээ. Төмөр хүрз хөлөг дээр байгаагүй учир тэр өөртөө нэгийг хийх хэрэгтэй болсон байна. Тэгээд түүнд байсан ганц материал нь мод байжээ.

Тэр маш хатуу үндэстэй мод олсон бөгөөд ажиллахад маш хэцүү байсан тэр өөрт хэрэгтэй хүрз хэлбэртэй хавтгай мод бэлтгэж чаджээ. Тиймээс тэр газрыг хагалж эрдэнэшишээ суулгах боломжтой болсон байна.

Гэвч энэ эхний ургац огт ургасангүй. Учир нь Робинзон жилийн буруу улиралд – яг гангийн улирлын өмнөхөн суулгасан байжээ. Тэр өөрийн үрнийхээ хагасыг энэ эхний суулгалтанд зарцуулсан байсан учир түүнд нөгөө хагас нь үлдсэн байжээ.

Түүний хоёр дахь ургац борооны улирлын яг өмнөхөн суулгасан учир маш сайн ургажээ.

Эрдэнэшишийг боловсрох үед нь Робинзон түрүү бүрийг нь болгоомжтой хурааж авчээ. Тэр өөрийн эрдэнэшишээ дахин тарьж өсгөх байгаад талхи хийхээр боджээ. Талх хийх болтол яг гурван жил шаардлагатай байлаа.

Робинзон арал дээр ирээд арван сар болж байх үедээ голыг дагаж арлын гүн рүү явж үзэхээр шийджээ. Голын эргээр зэрлэг тамхи, чихрийн нишингэ, боловсорч гүйцсэн амтат усан үзэм жүрж, зэрлэг нимбэгээр дүүрэн моддыг тэр олжээ. Эдгээр жимснүүдээс түүнд хамгийн үнэтэй нь усан үзэм болж таарчээ. Бусад жимснүүд нь түүж авсныхаа дараа муудахаас нь өмнө хурдан идэх хэрэгтэй байсан бөгөөд харин усан үзмийг ямар ч модны мөчрөөс өлгөж наранд хатаагаад үзэм болгох боломжтой байлаа. Тэднийг урт хугацаанд муутгахгүйгээр хадгалж болох байв. Тэд их амттай байсан төдийгүй маш их амин дэмтэй байв.

Усан үзэм борооны улирлын үед Робинзон агуягаасаа гарч чадахгүй хэдэн долоо хоног болох үед маш чухал үнэтэй хүнс болж чаджээ. Цаг агаар хэсэг зуур амсхийхэд тэр зөвхөн ойр хавьд нь явж байдаг ямаа, эсвэл яст мэлхий агнах гэж агуягаасаа гардаг байв. Гэвч борооны улирлын үеэр шинэхэн жимс арлын хэтэрхий гүнд хол ургадаг байжээ.

Робинзоны календарын модонд 365 зураас үүсэх үед тэр арал дээр хэзээ борооны болон гангийн улирал болдгийг мэддэг болжээ. Энэ нь жилд хоёр удаа ургац авахын тулд ургацаа суулгахад нь түүнд хэрэгтэй байв. Жилийн улирлууд Англид байсан шиг нь өвөл, зун гэж хуваагдахгүй, харин бороотой, хуурай, бороотой, хуурай гэж хуваагдаж байгаад тэр олж мэджээ. Цаг улирлыг мэдсэнээр Робинзон өөрийн хангамжаа сайтар нөөцөлж аваад чийгтэй саруудад гадагш их гарагчийг байх боломжтой болсон юм.

Гэртээ байхдаа тэр агуягаа томруулах, урт нарийн мөчрөөр сагс сүлжих зэргээр завгүй байдаг байлаа. Эдгээр сагснууд нь түүний эрдэнэшиш болоод үзмийг хадгалахад хэрэглэгддэг байсан бөгөөд мөн агуягаагаас шороо чулуу зөөж гаргахад ашигладаг байлаа.

Хоёр дахь жилдээ Робинзон арлыг судалж олон удаа явж үзсэн байв. Нэг аялалынхаа үеэр тэр өндөр ууланд – одоогоор олоод байгаа хамгийн өндөр ууландаа авирсан байна. Тэр өдөр маш цэлмэг байсан бөгөөд баруун зүтг дөчин милийн зайнд Робинзон газар илрүүлжээ. Тэрээр уг газрыг арал уу эх газар уу гэдгийг нь мэдэхгүй байжээ. Гэхдээ тэнд оршин суугчид байдаг бол тэр нь зэрлэгүүд байх болно гэдгийг тэр сайн мэдэж байсан юм. Бразилд хэсэг амьдарсан учраас Робинзон дэлхийн энэ хэсэгт оршин суудаг зэрлэгүүдийн тухай сонссон байлаа. Тэд каннибалууд, хүний мах иддэг, гартаа орсон бүх хүнийг иддэг байв. Каннибалуудын тухай бодол Робинзоныг айлгаж каннибалуудын дунд биш энэ алслагдсан аралд газардсандаа бурханд талархжээ.

Өөр нэг аялалынхаа үеэр Робинзон тоть шувууны сүргийг олжээ. Тэр нэгийг нь барьж аваад ярихад сургахаар шийдсэн байна. Тэгээд барьж авсан боловч тэр хөгшин шувуу “Робин Крузо! Робин Крузо!” гэж хэлж сурх хүртэл дөрвөн жил зарцуулжээ.

Тэгээд хоёр дахь өнгөрч гурав дахь жил эхлэв. Робинзоны ургац хангалттай их болсон байсан тул тэр бүх ургацаа дахин суулгахад зарцуулах шаардлагагүй болжээ. Тэр одоо өөрийн эрдэнэшишээрээ талх хийх тухай бодож эхлэх болов.

Гэхдээ тэр эхлээд маш их бодох хэрэгтэй байлаа. Учир нь түүнд эрдэнэшишээ гурил болгон бутлах тээрэм, шигших шигшүүр, хадгалах сав, талх барих зуух байсангүй.

Эхлээд тэрээр арлаас ухаж авсан хэсэг шавраараа туршилт хийж эхэлжээ. Тэр шавраа устай хольж зуурмаг бэлдээд зуурмагаа домбо хэлбэрт оруулж наранд тавьж хатаажээ. Түүний эхний хэдэн домбо нь үзэмж муутай, хэлбэргүй байсан бөгөд наранд тавих үед хагарч цуураад хэдэн хэсэг болж, эсвэл өөрийн жингээсээ болоод цөмөрч унаад байжээ.

Хоёр сар туршилт хийсний эцэст Робинзон хэд хэдэн жижиг шавар аяга, таваг, сав, домбо амжилттай хийж чаджээ. Гэвч түүний хийсэн хоёр том шавар эдлэл нь домбо гэж нэрлэхийн аргагүй муухай байжээ.

Одоо тэр бэлтгэсэн гурилаа хадгалах савтай болсон бөгөөд Робинзон эрдэнэшишээ гурил болгон тээрэмдэх чулуу олох хэрэгтэй байлаа. Араг дээр байсан чулуунууд маш зөвлөн бөгөөд амархан бутраад болж өгөхгүй байв. Тэгээд тэр оронд нь хүрз хийсэн модноосоо тайрч аваад дотор талыг нь хөндийлжээ. Дараа нь тэр нүдүүр буюу нухуур хийж эрдэнэшишээ бутлахад маш сайн болж байлаа.


Одоо гурилаа хальснаас нь салгах хэрэгтэй байв. Робинзонд ямар ч шигшүүр, түүнийг орлуулах нимгэн хувцас байсангүй. Тэгтэл тэр хөлгийн авдруудын нэгнээс нь авсан толгойн алчуурыг санав. Тэгээд түүний хэдэн утсыг нь сугалж аваад гурилаас хальсыг нь салгах шигшүүр хийж чаджээ.

Дараа нь талхаа барих асуудал гарч ирлээ. Робинзонд ямар ч зуух байсангүй, гэхдээ түүнд сэргэлэн ухаан байсан юм. Түүнд маш том хоёр шавар таваг хийх санаа төржээ. Талхаа нэг тавагт нь хийгээд нөгөөгөөр нь бүтээж бүтээсэн тавгаа халуун улаан галын нурманд хагас шургуулжээ. Тэгээд үлдсэн хагас нурмаар нь тавгаа бүх талаас нь хучиж тавив. Тэгээд түүний талх жигнэгдэж эхлэв.

Тэгээд араг дээрх гурав дахь жилийнхээ төгсгөлд Робинзон өөрийн аль хэдийнээ сурсан ан хий, ургац тариалах, мужаан хийх зэрэг чадварууд дээрээ талх барих чадварыг нэмж сурчээ.

1st-art-galler.com

This watermark does not appear on your art print.





## 5-р бүлэг

# Робинзон өвчүүн завь хийсэн нь

Робинзон арал дээр суурьшаад дөрвөн жил болж байгаа ч хоёр жилийн өмнө баруун эрэг рүү аялахдаа харсан газрыг хэзээ ч мартаагүй байлаа.

Тэр гэрээ сайн барьж, ургац нь ч мөн сайн ургаж байлаа. Робинзон одоо тэр нууцлаг газар луу далайгаар аялах тухай бодох цагтай болжээ. Магадгүй энэ нь түүнийг эх газар луу ч хөтөлж мэдэх байлаа.

Тиймээс Робинзон завь хийхээр шийджээ. Тэрээр Бразилын уугуул иргэд том модны ишээр өвчүүн завь хийдэг байсан тухай санажээ. Тэр ч бас үүнийг туршиж үзэх гэж байлаа.

Тэр зургаан фут өргөн иштэй том хуш мод олжээ. Тэр модыг цавчиж унагахад л гэхэд арван хоёр өдөр шаардагдсан бөгөөд мөчрүүдийг нь тайрч хаяхад дахиад арван дөрвөн өдөр болжээ. Дараагаар нь тэр хөвөх ёроолынх нь хэлбэрийг гаргах гэж нэг сарыг зарцуулсан бөгөөд дотор талыг нь алх, сүхээр хөндийлөхөд гурван сар болжээ.

Таван сарын дараа, Робинзон арван хоёр хүн багтхааар том завьтай болжээ. Тэр өөрийн ажилдаа сэтгэл хангалаун байлаа. Гэвч тэр завиа ус руу хэрхэн аваачих тухайгаа өмнө нь бодож үзээгүй байлаа.

Завь нь далайн булангаас зуун яардын зйтай, магадгүй дахиад зуун яардын зйтай байжээ. Завь ганц хүн түлхэхэд хэтэрхий хүнд байжээ. Тиймээс Робинзон завиа усанд аваачих санаагаа орхисон байлаа. Гэхдээ тэр таван сарын ажлаасаа сургамж авсан байлаа. Тэр сургамж нь аливаа төсөл эхлүүлэхээсээ өмнө төлөвлөх хэрэгтэй гэсэн сургамж байв.

Хэрвээ тэр өөр завь хийх бол илүү жижиг, илүү хөнгөн бөгөөд устай арай илүү ойр газар бэлтгэх хэрэгтэй байв.

Робинзон дараа нь анхаарлаа хувцсандаа хандуулжээ. Хөлөг онгоцноос авсан нэг л өмд, цамцтайгаа дөрвөн жил амьдарч, тэд нар нь бүр ноорхой болсон байжээ. Тийм халуун цаг агаарт хувцас өмсөх жинхэнэ шаардлага, ялангуяа тэнд өөр хүмүүс байгаагүй ч, Робинзон нүцгэн явж чадахгүй байлаа. Халуун нар ихэнхдээ түүний арьсыг нь түлж цэврүүтүүлээд толгойт нь маш их өвтгөдөг байсан тул тэр үргэлж өмд, цамц, малгай өмсч явах хэрэгтэй байлаа.

Түүний хувцас муудаж ирэх үед Робинзон шинэ хувцас хийхээр оролдох хэрэгтэй болов. Түүнд байсан ганц материал нь түүний агнасан амьтдын арьс байлаа. Тэр тэдгээр арьснуудыг наранд тэлж хатаасан байжээ. Ямааны арьс шиг зөөлөн хэвээрээ байсан арьснуудыг хэлбэрт оруулж хувцас болгон оёж болохоор байлаа.

Эхлээд тэр хүзүү рүүгээ унжсан унжлагатай малгай хийж өмсчээ. Гадна талын үс нь түүнийг аадар борооны үед хуурай байлгаж халуун нар толгой хүзүүг нь түлхээс хамгаалж байлаа.

Энэ нь их сайн болсныг үзээд Робинзон эдгээр арьснуудаас өөртөө хантааз хийхээр оролджээ. Тэр өөртөө сулхан урт хантааз болон өвдөгнөөсөө доош хүрсэн өмд хийж өмсчээ. Тэр бүх зүйлээ ямааны арьсан тэлээгээр тогтоосон байна. Энэ тэлээ нь бас өөр зорилгоор ашиглагдаж байсан юм. Тэр өөрийн хөрөө болон

жижиг сүхээ зүүжээ. Өөр нэг бүсийг мөрөө давуулан хийсэн бөгөөд түүнд нь ууттай бууныхаа дарийг уяжээ. Гадуур хувцасаа иж бүрэн болгох гэж Робинзон үдээстэй оймсон гутал шиг харагдах хос гутал өөртөө хийжээ.

Фермер эсвэл анчин эсвэл мужаан биш шигээ оёдолчин биш гэдгээ мэддэг болохоор Робинзон өөрийнхөө шинэ хувцасаар ихэд бахархаж байлаа.

Тэд маш сайн таарч байсан бөгөөд бороо ороход түүнийг хуурай байлгаж түүнийг ямар нэгэн ширүүн, аймшигтай амьтан мэт харагдуулж байлаа. Гэхдээ тэр арал дээр айх хүн байхгүй байлаа!

Дараа нь Робинзон өөртөө шүхэр хийхээр төлөвлөжээ. Халуун нар болоод аадар борооноос хамгаалах шаардлага нь шүхэр хийхэд хүргэжээ. Хоёр, гурван бүтэлгүйтлийн дараа Робинзон эцэст нь ямааны арьсаар бүрсэн мөчрөн шүхэр хийж чаджээ. Амархан нээгдэж хаагддаг байсан болохоор авч явахад авсаархан байжээ.

Арал дээрх тав дахь жилийнхээ төгсгөлд Робинзон өөр нэг өвчүүн завь хийж үзэхээр шийджээ. Түүний эхний оролдлого нь барьсан газраа байгаа бөгөөд түүнийг энэ удаад илүү ухаантай байхыг сануулж байсан билээ.

Робинзон сайн сургамж авсан бөгөөд хоёр дахь өвчүүн завиа арай жижиг, устай ойр газар хийжээ. Энэ удаад тэр завиа усанд оруулахад ямар ч бэрхшээлгүй байлаа. Хэдийгээр тэр завь нь түүний харсан газар луу түүнийг аваачихад хангалттай том биш байсан ч өөрийн арлын эргэн тойрноор аялахад хангалттай том байлаа.

Робинзон бяцхан шураг хийж өөрийн хөлөг онгоцны далбаанаас үлдсэн хэсгүүдээр далбаа хийжээ. Тэр дараа нь завины нэг талд хоол хүнсээ хадгалах авдар хийжээ. Тэр авдар нь хоол хүнсийг нь нар, бороо, тэнгисийн уснаас хамгаалах байлаа.

Дараа нь Робинзон шүхэрээ завины хитэгэнд бэхэлж сүүдрэвч хийжээ.

Далайн буланд хэдэн удаа туршилтын аялал хийсний дараа Робинзон өөрийн өвчүүн завиа далайд гаргаж үзэхэд бэлэн болжээ. Тэр зүүн зүгт аялах үед түүний зургаа дахь жил эхэлж байлаа. Түүний өмнө аварга том сэргэн хад тэнгис рүү бараг зургаан миль түрж орсон харагдаж байлаа. Тэр хадыг өнгөрөөд бараг гурван миль үргэлжилсэн хадан эрэг байсан бөгөөд энэ нь асуудал болж байлаа.

Энэ нь Робинзон сэргэн хад болон хадан эргийг тойрохын тулд бараг есөн миль аялах хэрэгтэй гэсэн үг юм. Түүний завь нь үүнийг давж чадна гэдэгт тэр итгэлтэй биш байлаа.

Тэгээд Робинзон завиа эрэгт аваачиж хаднуудын яг дэргэд бэхэлж уяжээ. Тэр далайг харуулдах боломжтой хаданд авирч тэр өндөр газраас өөрийн эргэн тойрны далайг илүү сайн харж чадаж байлаа. Дурангийнхаа тусламжтайгаар тэр хаднууд болон хадан эргийн цаана харагдах ширүүн урсгалыг харж чаджээ. Робинзон хэрвээ хаднуудыг тойрч явбал тэр урсгалд ороод эргэж эрэгтээ ирж чадахааргүйгээр далайд алслагдан одоо гэдгээ мэдээд ихэд айжээ.

Гэвч Робинзон Крузо бол зоригт далайчин байсан юм. Тэр урсгалтай тулалдах байсан юм.

Тэгээд олон цагийн турш тэр өөрийн төсөөлж байснаас ч догшин урсгалтай тулгарч хичнээн сэлүүрдэвч давж чадахгүй байлаа. Таван цагийн дараа гар нь яг л мөрнөөсөө салж унах гэж байгаа юм шиг мэдрэгдэж эхлэх үед тэнгисийн зөөлөн салхи үлээж түүнийг урсалаас гаргасан юм. Гэвч яг ямар чиглэлд туугдаж яваагаа

тэр мэдэхгүй байсан юм. Тэр арлаа харахгүй байсан бөгөөд өөрийн луужингаа авч гараагүй байжээ.

Гэвч бүтэн өдөр бүрхэж байсан үүлс эцэстээ сарниж нар тусч эхэлжээ. Тэнгэр дэхь нарны байрлал Робинзоныг баруун тийш явж байгааг илтгэж байлаа.

Салхи үлээж байсан учир Робинзон далбаагаа дэлгэж цааш явж чадахаар болов. Хэдэн цагийн дараа арлын хойд эрэг харагдаж Робинзон газардах боломжтой болжээ.

Хоол идэж хэсэг зуур нойр авсныхаа дараа Робинзон арлын өөрийн байсан эрэг рүү яаж очих тухай бодох хэрэгтэй болжээ. Өвчүүн завиараа ирсэн шигээ буцаж явахаар оролдох нь хэтэрхий эрсдэлтэй байлаа.

Гэвч арлын баруун хэсэг рүү буцаж явах нь бас аюултай байлаа. Учир нь тэнд далай ямархуу байгааг тэр мэдэх аргагүй байсан юм.

Тиймээс тэр өвчүүн завиа газар дээр татаж гаргаад бэхлэн уяж гэрлүүгээ алхаж явахаар шийджээ.

Олон сарын хүнд хөдөлмөрийнхөө эцэст завьгүй баймааргүй байсан ч Робинзон тэр үед дахиад ямар ч адал явдалтай учрах сонирхолгүй байсан юм.

Тиймээс зөвхөн буу болон шүхрээ аваад Робинзон эргийн дагуу гэрийн зүг холын явган аяллаа эхэлжээ.



## **6-р бүлэг**

# **Нууцлаг хөлийн мөр**

Робинзон дараагийн таван жилийг маш нам гүмхэн амьдарч өнгөрөөжээ. Арван нэг дэхь жил гэхэд түүний бууны дарь нь дуусч эхэлж байлаа. Тэр түүнийгээ зөвхөн ан хийхэд ашигласан байжээ. Гэвч дарь дууссаны дараа тэр хэрхэн ан хийх билээ?

Тэрээр занга тавьж номхруулж идэшиндээ зориулж тэжээхэд хангалттай их ямаа барихаар шийджээ. Түүний эхний хавх нь газарт ухсан нүх байсан бөгөөд гурван залуу ямаар барьсан бөгөөд нэг эр, хоёр эм ямаа байлаа.

Жил хагас орчмын дараа тэр арван хоёр ямаатай сүрэгтэй болсон байсан бөгөөд хоёр жилийн дараа гэхэд дөчин гурван ямаатай болжээ.

Одоо тэр гаршуулсан сүрэгтэй болсон бөгөөд, Робинзон тэднээсээ маш болон сүү авч болох юм гэдгийг ойлгожээ.

Робинзон амьдралдаа хэзээ ч үхэр сааж үзээгүй байсан бөгөөд мэдээж ямаа ч сааж үзээгүй байжээ. Мөн түүнд тос, бяслаг хэрхэн хийх тухай ямар ч төсөөлөл байсангүй. Гэхдээ маш олон оролдлого бүтэлгүйтлийн эцэст тэр аль алийг нь хийж сурчээ.

Робинзон завиа арлын хойд хэсэгт орхисноос хойш долоон жил өнгөрсөн байлаа. Тэр эхлүүлсэн аяллаа дуусгах гэж тэсэн ядаж байлаа. Тэр өвчүүн завиа буцаан авчрах хэрэгтэй байлаа!

Тиймээс Робинзон эргийн дагуу зүүн зүг рүү алхаад дараагаар нь хойд зүг рүү явахаар төлөвлөж аялалд гарчээ. Тэрээр сэргтэн хад болоод хадан эргийг харуулдах ууланд хүрээд тэнгис намуун тогтуун байгааг үзэв. Олон жилийн өмнө тулгарсан ширүүн урсгалын ямар ч шинж түүнд үзэгдсэнгүй. Яагаад энэ өөрчлөгдчихөв? Дараа нь Робинзон давалгаа байхгүй болсон байгааг харлаа. Тийм байсан байна! Давалгаа байхгүй хооронд тэр эндүүр буцаж ирж болох байлаа. Учир нь давалгаа эрэгт эргэж ирэхэд тэр урсгал дахин эхэлж байжээ.

Нээлтэндээ ихэд баярласан Робинзон уулаас бууж эрэг рүү буцан ирлээ. Тэр элсэн дээр тав ч алхалгүй зогтусав. Тэнд, түүний өмнө, түүний гишгээгүй газар хүний хөлийн мөр байжээ!

Робинзон хэдэн минут балмагдан зогсчээ. Тэр бол хүний мөр байсан юм. Хөлийн хуруу, өсгий, хөлөнд байдаг бүх хэсэг тэр мөрөнд байлаа. Мөн тэр мөр түүнийхээс хамаагүй том байсан юм.

Робинзон эргэн тойрноо харж чагнан зогсов. Юу ч алга! Тэр уул руу буцан авирч эргэн тойрноо сайтар харуулдав. Бас л юу ч алга байлаа! Тэрээр эргийн дагуу хоёр тийш гүйсэн боловч тэнд хэнийг ч, бас өөр ямар ч хөлийн мөр харсангүй.

Өвчүүн завиныхаа тухай бүх бодлоо мартсан Робинзон аиж сандран гэрлүүгээ яaran явлаа. Алхах бүртээ тэр мод бүрийг, бут бүрийг хүн байна гэж төсөөлж эргэж байлаа. Тэр цайзынхаа дотор орж аюулгүй болох хүртлээ тайвширч чадсангүй.

Тэр шөнө Робинзон огт унтаж чадаагүй байна. Чөтгөр түүн дээр ирсэн гэсэн бодол түүний толгойд эргэлдэж байлаа. Учир нь тэр арал руу яаж хэн нэгэн хүний

төрлийн зүйл очиж чадах билээ? Тэнд ямар ч завинь шинж тэмдэг байхгүй байсан юм! Бас тэнд яагаад өөр хөлийн мөр байгаагүй юм бол?

Дараа нь өөр нэг, бүр аймшигтай бодол түүнд төрсөн юм. Магадгүй хэсэг зэрлэг хүмүүс эх газраас урсгалд туугдан тэр арал дээр ирсэн байж болзошгүй байлаа. Магадгүй тэд түүний завийг олоод одоо түүнийг хайж байж болзошгүй байлаа. Тэд тэднийг алж идэх нь тодорхой байсан юм!


Гурван өдөр, гурван шөнийн турш Робинзон цайзаасаа толгойгоо ч цухуйлгасангүй. Эцэст нь түүний эр зориг эргэн ирж эхлэхэд тэр илүү ухаалгаар бодож эхэлжээ.


Тэр одоо арал дээр арван таван жилийн турш амьдарсан бөгөөд тэр бүх хугацаанд тэр ямар хүний амьдралын ул мөр хараагүй юм. Тэгвэл яагаад хөлийн мөр шиг жаахан зүйлээс болж санаа зовох хэрэгтэй гэж?

Робинзон айдсаасаа гарах гэж их шургуу оролджээ. Гэвч ядаж бэлтгэлтэй байхын тулд тэр цайзаа бэхлэхээр шийджээ. Тэр бүдүүн шонгоор эхний ханаа тойруулаад хоёр дахь хана барьж хөлөг онгоцноос авсан долоон бууг хананыхаа шонгуудын хооронд байрлуулжээ.

Энэ хоёрдахь ханыг барихад Робинзон нэг сарыг зарцуулсан бөгөөд ингэж дууссаныхаа дараа ч тэр тайван бус хэвээр байлаа. Тэр зэрлэг каннибалуудын гарти орохоос айсан хэвээрээ л байлаа.

Түүний айдас нь бодитой байсан гэдгийг Робинзон бага зэрэг ойлгож байсан юм. Эдгээр зэрлэгүүд дайрах аюул байсан юм!









1stdibs gallery.com  
The watermark above is not part of the painting.

## 7-р бүлэг

# Каннибалууд!

Дараах хоёр сарын турш Робинзон хөлийн мөр харсан арлын зүүн үзүүрээс хол байжээ. Оронд нь тэр ганцхан удаа л очиж үзсэн баруун үзүүрийг судлахаар шийджээ.

Тэрээр тэнгис рүү харсан уулын оройд хүрэхдээ алс холд завь харагдахыг үзжээ. Гэвч тэр дурангаа авч гарсаагүй байсан учир баттай мэдэж чадсангүй. Гэвч хэдэн минутын дотор тэр завь үзэгдэхгүй болжээ.

Робинзон тэнгис рүү анхаарахаа больж уулын руу зүглэж байхдаа амьдралдаа аиж байгаагүйгээрээ аиж үхсэн юм шиг хөдөлгөөнгүй болов.

Газар дээр бутарч тарсан гар, гавлын яс, хөл болон хүний бусад ясуудыг хараад “Өө, Бурхан минь!” гэж тэр орилжээ. Ойролцоо нь галын үлдэгдэл байлаа.

“Зэрлэгүүд энд байсан байна. Тэгээд тэд өөрсдийн адил хүн төрөлтнөө харгисаар барьж идсэн байна!” гэж тэр орилов.

Робинзон энэ аймшигт зүйлсээс холдож гэдэс нь их өвдөж үхэдхийн унажээ. Тэгээд удалгүй хяналтаа алдаж бөөлжиж эхлэв.

Хэдэн минутын дараа бөөлжиххөө больсны дараа Робинзон эргэж уулын өөд хөлийнхөө хурдаар гүйн гарав. Тэр цайз хүртлээ огт зогсолгүйгээр гүйж очоод дахиж арлын баруун үзүүрт очихгүй гэж тангараглажээ.

Дараагийн хоёр жилийн турш Робинзон цайзаасаа гарах бүртээ өмнөхөөсөө илүү хянамгай, сонор сээрэмжтэй байх болжээ.

Тэр бүр арал дээр байж магадгүй зэрлэгүүд сонсчихож мэднэ гээд буугаараа буудахаа ч больжээ. Робинзон ямаа гаршуулж дахин ой модонд ан хийх шаардлагагүй болсондоо илүү их баяртай байлаа. Гэхдээ буугаараа буудахгүй байсан ч бүх цагийн турш тэр буу болон гар буу, сэлмээ өөрөөсөө салгахаа больжээ.

Тэдгээр урт саруудын турш Робинзоны айdas аажмаар уур хилэн болон хувирчээ. Тэрээр хэрэв зэрлэгүүдийг харгис зоогийнх нь үеэр олвол дайрах тухай төлөвлөгөө боловсруулж эхэлжээ. Олон зэрлэг төлөвлөгөө толгойд нь орж ирсэн боловч аль нь ч бодитой санагдсангүй. Тэрээр ганцаараа яг өөрийнх нь буу шиг оновчтой, бас аминд хүрэхээр нум сумтай хорь, гучин зэрлэгийн эсрэг зогсох байлаа.

Гэвч дайралтын тухай тэр бодох тусам, өөрөө өөрөөсөө илүү их асууж эхэлжээ.

“Надад тэдгээр хүмүүсийг шүүх, хөнөөх эрх бий бил үү? Би тэднийг гэмт хэрэгтэн гэж үзэж болох ч тэд өөрсдийн хүмүүсийн олон жилийн турш хийсээр ирсэн зүйлийг л хийж байгаа шүү дээ. Магадгүй тэд би ямааны мах идэхээ нүгэл гэж үздэггүй шиг хүний мах идэхийг нүгэл гэж үздэггүй байж болох.”

“Тэгээд ч эдгээр хүмүүс надад ямар ч хор хүргээгүй. Тэд энэ арал дээр над руу довтлох гэж ирээгүй. Тиймээс, яагаад би тэдэн рүү довтлох хэрэгтэй гэж? Би магадгүй хоёр, гурван каннибал алж болох юм, магадгүй тав, зургааг. Гэвч тэдний бусад нь зугтаачихвал тэд зуу зуун бусадтайгаа хамт ирж өөрийн хүнийхээ өшөөг авахын тулд намайг алж идэх болно” гэж Робинзон үргэлжлүүлэн бодов.

Тиймээс Робинзон эцэст нь каннибалуудыг дахин харвал нуугдах нь хамгийн мэргэн байх болно гэж шийджээ. Тийм замаар, тэд өөр хүн энэ арал дээр байгаа гэж хэзээ ч таамаглахгүй юм.

Гэсэн ч үргэлжийн аюулын айдас Робинзоныг орхисонгүй. Тэр цайзаасаа зөвхөн шаардлагатай үед л гарч байлаа.

Тэрээр амьдралаа илүү хөнгөвчлөх шинэ зүйл хийх тухай бодохоо болжээ. Учир нь хадаас хадах чимээ, эсвэл мод цавчих чимээ сонстох болно. Тэр бүр гадаа гал түлэхээ болж утаа түүнийг барьж өгөхөөс айн агуй дотроо хоолоо хийх болжээ. Одоо цорын ганц чухал зүйл, бүр хоол хүнснээс ч илүү чухал зүйл бол түүний аюулгүй байдаг байлаа.

Робинзон арал дээр хорин гурван жилийн турш байсан юм. Тэр цуст нээлтээс хойш дөрвөн жил өнгөрчээ. Тэр дөрвөн жилийн хугацаанд каннибалууд ирсэн гэсэн ямар ч шинж тэмдэг мэдэгдсэнгүй. Робинзон дахиж ямар ч зэрлэг ирж түүнд төвөг болохгүй гэдэгт бараг л итгэсэн байлаа.

Гэвч түүний хорин гурав дахь жилийнх нь өвөл Робинзоны тайван амьдрал алдагджээ. Нэг өглөө эрт арлын түүний амьдарч байсан эргээс утаа гарахыг тэр олж үзжээ. Тэр шатаа цайзынхаа дэргэдэх ууланд түшүүлэн тавьж орой руу нь авирч гарав. Тэр гэдсээрээ хэвтээд дурангаараа галыг хайж эхэлжээ.

Дурангийн дугуй тойрог удалгүй жижиг гал тойрон суугаа есөн зэрлэгийг илрүүлжээ. Гэвч тэд удалгүй өвчүүн завиндаа сууж сэлүүрдэн одов.

Тэд харагдахаа больмогц Робинзон буугаа авч эргийн зүг хөдлөв. Цус, яс, хүний махын хэсгүүд элсэн дээр хэвтэж байлаа. Робинзоны хуучин аллагын мэдрэмж эргэн ирж дараагийн удаа зэрлэгүүд энэ арал дээр хөл тавих юм бол устгана гэдгээ тангараглажээ.



## 8-р бүлэг

# Хүний хоолойн анхны чимээ

Дараагийн жилийн турш Робинзон арлаас явахаас өөр зүйлийн тухай бодоогүй билээ. Одоо тэр ярилцах хэн нэгэн, хаана байсан тухайгаа хэлэх хэн нэгэн, бас түүнийг аврах хэн нэгнийг хүсч байлаа.

Испанийн хөлөг онгоц хадан эргийн ойролцоо өнгөрөхөөс хэдэн сарын өмнө хүртэл түүний аврагдах хүсэл маш их байлаа. Гэвч Робинзон завин дээрээ очиж хөлөг онгоц руу сэлэн очтол үхсэн цогцсууд, бага хэмжээний ачаанаа өөр зүйл олсонгүй. Тэр ачаануудыг эрэг рүү аваачжээ. Бялттай буунууд, дарь болон хувцас түүнд хэрэг болохоор байлаа.

Мөн цорын ганц амьд үлдэгч, хөлөг онгоцны нохой түүний олон жилийн өмнө үхсэн нохойных нь орыг дарж байлаа.

Гэвч түүний олсон шуудай алтнууд хичнээн хэрэггүй байсан гээч! Тэд түүнд ярилцах өөр хүнийг худалдаж авч өгч чадахааргүй байлаа.

Явах бодол Робинзоны дотор тэсэхийн аргагүй ихээр төрөх болжээ. Тэрээр энэ тухай өдөр нь бодож шөнө нь зүүдэлж байжээ. Яг ижил зүүд дахин дахин, шөнө бүр давтагдаж байлаа. Зүүдэнд нь зэрлэгүүд олзлогдогчийн хамт арал дээр ирж үзэгджээ. Тэр олзлогдогч зэрлэгүүдээс зугтааж Робинзон дээр тусламж хүсэн очжээ. Робинзон түүнийг оруулж нуугаад удалгүй үнэнч зарцтай болжээ. Энэ олзлогдогч, нутгийн угуул түүнд эх газар луу гарахад нь туслах байлаа.

Энэ зүүд маш бодитой санагдаж Робинзоны аврагдах цор ганц зам нь зэрлэгүүдийн авч ирэх олзлогдогсодын нэгийг аврах явдал гэж Робинзон шийджээ. Дараа нь түүний зүүдний үлдсэн хэсэг нь биелэх байлаа.

Тиймээс Робинзон эргийн зүг харуулдаж эхэлжээ. Тэр зургаан сарын турш харуулджээ, тэр жилийн турш харуулджээ, тэр жил хагасын турш харуулджээ. Гэвч ямар ч өвчүүн завь далайд үзэгдэхгүй байлаа.

Тэгээд нэг өглөө, арал дээрх хорин тав дахь жилдээ Робинзон өөрийн хайж байсан завиудаа олж үзжээ. Арлын түүний байсан талд эрэг дээр таван завь зогссон байсан бөгөөд тэдэнд сууж явсан зэрлэгүүд аль хэдийн газардаж харагдахаа больсон байлаа. Гэвч таван завь гэдэг бол хорь, эсвэл гучин хүн гэсэн үг байлаа! Робинзон тэдэн рүү ганцаараа хэрхэн довтолж чадах билээ?

Тэрээр цайзынхаа дэргэдэх уулын орой руу авирч гучин хүн гал тойроод бүжиглэж байгааг харжээ. Тэд мах шарж байсан боловч тэр нь яг ямар мах гэдгийг Робинзон мэдэхгүй байлаа.

Түүнийг харж байтал хоёр хүнийг завьнаас гарган галын зүг чирч яваа нь харагдав. Нэгийг нь тэр даруй цохиураар цохин унагаж каннибалууд түүнийг хэрчиж эхлэв.

Нэгөө нэг олзлогдогч нь идэгдэхээ хүлээн зогсч байлаа. Ямар ч хамгаалалтгүй амиа аврагдахад найдаад зогсч байсан тэр уугуул гэнэт тэднээс үсрэн зугтаж мод руу гүйгээд орчихов гэнэ. Тэр Робинзоны чиглэлд гүйж байлаа.

Робинзон эдгээр явдлуудыг хараад “Миний мөрөөдөл биелж байгаа юм гэж үү?” гэж гайхахгүй байж чадсангүй. Тэгээд тэр анхаарлаа зэрлэгүүд рүү дахин

хандуулж тэдний зөвхөн гурав нь зугтааж буй уугуул иргэнийг хөөж байгааг харжээ.

Робинзон зэрлэгүүдэд гүйцэгдэхгүй зугтаж буй уугуулыг хараад чимээгүйхэн баярлажээ. “Гүйгээд бай, залуу минь! Чи чадах болно оо” гэж тэр шивнэв.

Тэгээд тэр уугуул голын цутгаланд хүрч ирэв. “Гүйя, Бурхан минь. Тэр хүнийг сэлэхэд нь, илүү сайн хурдан сэлэхэд нь туслаач!” гэж Робинзон залбирч байлаа.

Тэр хүн шумбан орж хүчтэй, хурдтайгаар сэлж голын цутгаланг хэдхэн секунтын дотор гаталжээ. Гурван зэрлэгийг голын цутгаланд хүрэх үед тэдний зөвхөн хоёр нь хэрхэн сэлэхийг мэддэг юм шиг харагдаж байлаа. Гурав дахь нь чаддаггүй байсан учир эргээд далайн эрэг рүү буцжээ.

Тэр хоёр зэрлэг уугуул иргэн шиг хурдан биш байсан учир тэднийг голын цутгалангийн нөгөө эрэгт хүрэх үед уугуул маань тэднээс нэлээд тасарч холдсон байлаа.

Энэ үед Робинзон тэр хөөрхийлэлтэй уугуулын амийг аврах нь өөрийнх нь хувь тавилан юм байна гэдгийг мэджээ. Тэрээр шатаараа доош бууж буугаа ваад цайз руугаа авиран гарч голын цутгалан руу зам дөтлөн явав.

Хэдхэн минутын дотор Робинзон зугтааж буй уугуулаас аравхан футын ард зогсч байлаа. Тэр түүнийг дуудаход уугуул эргэж хараад Робинзон руу ширтэж байлаа. Робинзон үүн рүү даллаад эргээд ир гэж дуудаход уугуул хэтэрхий айсан байсан учир хөдөлж чадахгүй байлаа.

Удалгүй Робинзон зэрлэгүүдийн ирж явааг сонсчээ. Тэрээр буугаараа буудаж бусдад нь мэдэгдэхийг хүсээгүй учир эхний зэрлэгийг бууныхаа араар цохиж унагажээ.

Хоёр дахь зэрлэг өөрийн наиз руу нь довтолж байгааг хараад нум сумаа гаргахад Робинзонд түүнийг цохиж унагах цаг байгаагүй учир аргагүйн эрхэнд бууджээ. Тэр зэрлэг үхэдхийн унажээ.

Айсан уугуул газар хэвтэх дайснууд руугаа ширтэж байлаа. Тэрээр Робинзоны буун гал болоод буун дуунаас их айсан байсан учир хөдөлж чадахгүй байв.

Робинзон түүнийг дахин дуудаж түүнийг ойртоод ир гэсэн дохиог өгч байлаа. Тэр хүн алхах бүртээ дагжин чичирч байсан ч Робинзон руу алхсаар байлаа. Тэрээр ойртох zuураа арав, эсвэл арван хоёр алхам бүртээ газар өвдөглөж байв. Энэ нь түүний амийг нь аварсанд талархаж буй хэлбэр байлаа.

Робинзон түүн рүү инээмсэглэж байв. Тэр хүн ойртон ирж Робинзонд хүрэхдээ тэр дахин газар өвдөглөж газрыг үнсэв. Дараа нь толгойгоо газар тавиад Робинзоны хөлийг толгойн дээрээ тавьжээ. Энэ нь үүрд Робинзоны боол байна гэдгээ андгайлж байгаа түүний арга байлаа.

Робинзон түүнийг дээш босгож мөрөн дээр нь зөөлөн алгаджээ. Тэгтэл цохиулж унасан эхний зэрлэг хөдөлж эхэлжээ. Робинзон түүн рүү онилоход уугуул Робинзоны ойлгохгүй хэлээр ямар нэгэн үг хэлэв. Гэхдээ тэдгээр үгс Робинзоны чихэнд маш тааламжтай байлаа. Учир нь тэр бол хорин таван жилийн турш Роинзоны сонссон өөрийнх нь биш анхны хүний дуу хоолой бай-лаа.

Гэвч тэр дуу хоолойг таашаах цаг байсангүй. Учир нь тэр зэрлэг аль хэдийнээ босч ирж байлаа. Өнөөх уугуул Робинзоны бүсэнд зүүлгээстэй байсан сэлэм рүү заахад Робинзон сэлмээ сугалан түүнд дамжуулав. Сэлэм гарг нь ормогц тэр дайсан руу гүйн очиж ганц цавчилтаар толгойг нь унагажээ.

Ажил дуусахад уугуул Робинзон руу буцан очиж сэлмийг хөлд нь тавив. Тэгээд тэр Робинзоны буудсан зэрлэг рүү очиж үхсэн биенийг нь ихэд гайхсан янзаар ажиглаж байлаа. Тэр зэрлэгийг тийм хол зайнаас огт хүрэхгүйгээр хэрхэн алсныг нь гайхаж байгаа гэдгийг Робинзон ойлгож байлаа. Робинзон зөвшөөрөл өгч толгой дохиход уугуул биенийг эргүүлэн тал бүрээс нь шалгаж байлаа. Цээжинд нь үүссэн жижиг нүх түүнийг гайхшуулан толгойгоо сэгсрэхэд хүргэжээ. Робинзон дараа нь тайлбарлаж өгөх байсан юм. Харин одоо бол хоёуланг нь оршуулж бусдад нь мэдэгдэхгүй болгох хэрэгтэй байлаа.

Тэгж дууссаны дараа, Робинзон уугуулыг цайздаа дагуулан буцаж ирэв. Тэнд түүнд хоол, ус өгч тэр ядарсан залууд хэвтэж амрах байр бэлдэж өгчээ. Хэдэн минутын дотор тэр хөөрхийлэлтэй амьтан нам унтжээ.



## 9-р бүлэг

# Баасан

Робинзон нойрсож буй залууг хараад зогсч байлаа. Тэр царайлаг, өндөр, бие бялдар сайтай залуу байсан бөгөөд Робинзон түүнийг ойролцоогоор хорин зургаан настай гэж таамаглаж байлаа. Түүний урт, шулуун, хар үс нь дугуй, булцгар нүүрийг нь хүрээлээд унтаж байхад нь хүртэл нүдэнд дулаахан харагдуулж байлаа.

Хагас цагаас илүүгүй хугацаа өнгөрөхөд залуу сэрг Робинзоны ямаагаа сааж буй агуин зүг гүйж иржээ. Тэр толгойгоо газар тавиад урьдын адил Робинзоны хөлийг толгой дээрээ тавилаа. Дахиад тэр хүн өөрийн үнэнч байлаа илэрхийлж үүрд Робинзоны боол байх болно гэдгээ андгайлж байсан юм.

Тэгээд Робинзон Крузогийн хувьд шинэ амьдрал эхэлж тэр залуу уугуулыг Баасан гэж нэрлэжээ. Робинзон хорин таван жилийн турш хөтөлж ирсэн календарийн шонгийн дагуу тэр хүний амийг аварсан өдөр нь Баасан гариг байсан юм.

Яг тэр шөнө, Робинзон түүнд өөрийн нэрийг заагаад өөрийг нь “Эзэн” гэж дудаж байхыг бас заажээ. Дараа нь тэр Баасанд “тийм”, “үгүй” гэсэн үгнүүдийг зааж өгөөд ямар утгатай болохыг нь мөн зааж өгчээ.

Робинзон нүцгэн залууд өмсөх хувцас өгөв. Ингэж тэр эзнийхээ нэгэн адил ямааны арьсан өмд, хүрэм малгайтай болжээ. Хэдийгээр эхлээд хувцас өмсөхөд жаахан эвгүй, тухгүй байсан ч энэ нь Баасанд маш их таалагдаж байлаа.

Дараах өглөө нь Робинзон Баасан хоёр уулын оройд гарч зэрлэгүүдийг харуулджээ. Тэд болоод тэдний завины ямар ч шинж харагдсангүй.

Тэд хоёр найзыгаа хайх ч үгүйгээр яваад өгсөн байлаа. Тэр өдрийн оройхон нь Робинзон Баасан хоёр өнөөх хоёр каннибалыг оршуулсан газрын дэргэдүүр зөрж байхад Баасан тэднийг ухан гаргаж идэхийг хүсч байгаагаа дохиогоор үзүүлжээ. Үүнд нь Робинзон ихэд хилэгнэж энэ тухай бодоход бөөлжмөөр болж байгаагаа илэрхийлэв. Тэр Баасанг тэр газраас хол дуудаж залуу ч түүнийг дуулгавартай дагав. Робинзон Баасангийн өөрийн хүмүүсээсээ сурсан каннибалын замд төгсгөл тавих ёстой гэдгийг мэдэж байлаа.

Хамтдаа тэд эргийн зүг очиж каннибалуудын зоогоос үлдсэн зүйлсийг цуглуулжээ. Тэд бүх зүйлсийг үнс болгон шатаасан байна.

Өдөр хоногууд өнгөрөхөд Робинзон Баасанг хүүхэд эцгээ хайрладаг шиг өөрийг нь хайрладаг үнэнч, шударга зарц гэдгийг нь мэдэрч байлаа. Робинзон үүнд нь маш их баяртай байсан бөгөөд Баасанд эзэндээ туслахад хэрэг болох бүхнийг зааж өгчээ.

Гэхдээ Баасанд хамгийн чухал чадвар нь хэл байлаа. Тэр Англи хэл сурч Робинзоны хэлсэн бүхнийг ойлгох ёстой байлаа. Баасан хичээлдээ дуртай маш сэргэлэн сургач гэдгээ баталж байсан юм. Тэр хурдан, сайн суралцаж байлаа.

Тэгээд хоёр жил өнгөрчээ. Робинзоны амьдрал Баасанг найз бөгөөд зарцаа болгож авснаар илүү хялбар, аз жаргалтай болжээ. Хэрвээ каннибалуудын довтолгооноос аюулгүй байж чаддагсан бол Робинзон хэзээ ч арлаа дахин орхихыг хүсэхгүй байх байлаа.

Баасангийн Англи хэл Робинзоны олон жилийн турш гайхширч явсан олон асуултуудад хариулж чадахаар сайн болсон байлаа. Баасан энэ арал дээр хүмүүсийн зоог болохоор ирэхээсээ өмнө олон удаа ирж байсан бөгөөд тийм учраас далай болоод түүний урсгалын тухай бүгдийг мэддэг байв. Тэр эх газраас ирэх нэг хүчит урсгалын тухай хэлсний нэлээн дараахан нь Робинзон түүнийг арлаас холгүйхэн Карибийн тэнгис рүү цутгадаг Өмнөд Америкийн томоохон Ориноко мөрөн болохыг мэджээ.

Баасан Робинзонд өөрийн орон, өөрийн хүмүүс, далай, эрэг болоод ойролцоо үндэстнүүдийн тухай ярьж өгчээ. Тэр мөн Робинзонд түүний үндэстэн амьдардаг газраас баруун зүгт хол явахад “Тань шиг цагаан сахалтай хүмүүс байдаг, Эзэн минь” гэж хэлжээ. Учир нь Робинзон нямбайлан зассан их цагаан сахалтай байсан юм.

Робинзон Баасангийн ярьсан цагаан хүмүүс нь Өмнөд Америкийн зарим хэсэгт суурьшсан Испаничууд гэдгийг ойлгож байлаа. Тэд магадгүй түүний арлаас явах хариулт болох байсан юм.

Робинзон арлаас явж тэдгээр цагаан хүмүүсийг олж болох эсэхийг асуухад Баасан “Тийм, тийм, хоёр завиар” гэж хариулжээ.

Эхлээд Робинзон “хоёр завиар” гэдэг нь ямар учиртай болохыг ойлгосонгүй. Гэвч Баасан удалгүй энэ нь хоёр завь шиг том завиар гэсэн утгатай болохыг тайлбарлажээ.

Баасан Англи хэлийг улам ойлгох болох үед Робинзон түүнд өөрийн амьдрал болоод арал дээр хэрхэн ирсэн тухайгаа ярьж өгчээ. Тэр өөрийгөө Англид хэрхэн амьдардаг байснаа, хэрхэн тэд дэлхийн бусад хэсэгтэй худалдаа хийдэг байснаа, мөн тэд хэрхэн Бурхныг шүтдэг байсан тухайгаа ярьж өгчээ.

Робинзон өөрийн хөлөг онгоцны сүйрлийн тухай тайлбарлаж өгөөд хөлөг онгоцныхоо аврах завийг үзүүлэхээр Баасанг дагуулж явжээ. Тэр хорин долоон жилийн өмнө сүйрсэн яг тэр эрэг дээрээ байж байлаа.

Баасан аврах завийг хэсэг судлаад, “Би үүн шиг завь манай үндэстэн дээр ирж байсныг харсан. Цагаан хүмүүсээр дүүрэн зав. Бид цагаан хүмүүсийг живэхээс аварсан” гэж хэлжээ.

“Тэнд хэдэн цагаан хүн байсан бэ?” гэж Робинзон асуухад Баасан хуруугаа дээш дахин дахин арван долоо хүртэл өргөжээ.

“Тэдэнд юу тохиолдсон юм бол?” гэж Робинзоныг асуухад,

“Тэд амьдарч байгаа, тэд манай үндэстэнд амьдарч байгаа” гэж Баасан хариулжээ.

“Хэрвээ тэдгээр хүмүүс аврах завиар ирсэн бол, тэд хөлөг онгоцны сүйрэлд байсан байж таарна. Магадгүй тэр сүйрэл манай хаданд болсон байх. Хүчит урсгал тэднийг эх газар луу түлхэж тэд танай үндэстэн дээр газардсан байх” гэж Робинзон хэлэв.

“Цагаан хүмүүс Баасангийн хүмүүстэй хамт нэг, хоёр, гурав, дөрвөн жил” гэж Баасан тайлбарлав.

“Танай хүмүүс яагаад тэднийг алж идээгүй юм бэ?” гэж Робинзоныг асуухад,

“Тэд тэдэнтэй ах дүүс болсон” гэж Баасан хэлээд, тэд найрамдсан гэж тайлбарлажээ. Тэгээд бас “Манай үндэстэн дайнаас бусад үед хүний мах иддэггүй. Баасан шинэ хааны төлөөх дайнд явж байгаад баригдаж энд ирсэн” гэж тэр нэмж өгүүлжээ.

Робинзон тэр залууг өөрийн хүмүүстэйгээ эргээд хамт байхыг нууцхан хүсч байгаа эсэхийг нь гайхаж, “Баасан, чи өөрийн орондоо дахиад байхыг хүсч байна уу?” гэж асуув.

Баасан толгой дохиод инээмсэглэж, “Би өөрийн үндэстэндээ байвал маш их баярлана” гэж хэлжээ.

“Чи тэнд юу хийх вэ? Чи эргээд зэрлэг болж хүний махыг идэх үү? Чи өмнөх шигээ зэрлэг болох уу?” гэж Робинзон асуужээ.

Баасан толгой сэгсрээд үндүйцсан харагджээ. “Үгүй, үгүй!” гэж тэр орилоод, “Баасан хүмүүст сайн амьдрахыг, бурханд залбирхыг, эрдэнэшишийн талх идэхийг, малын мах, сүүг хэлэх болно. Дахиж хүн идэж болохгүй гэж хэлнэ” гэв.

“Гэвч тэд чамайг үүний чинь төлөө алхагүй гэж үү?” гэж Робинзоныг асуухад,

“Үгүй, тэд намайг алхагүй. Тэд суралцахад бэлэн байгаа. Тэд завиар ирсэн цагаан сахалтай хүмүүсээс их зүйл сурсан” гэж тэр хариулав.

“Тэгвэл чи буцаж явах уу?” гэж Робинзоныг асуухад,

Баасан инээмсэглээд, “Би тийм хол сэлж чадахгүй” гэж хариулав.

“Гэхдээ би чамд завь хийж өгвөл яах вэ?” гэж Робинзоныг асуухад,

“Тэгвэл Баасан явна, гэхдээ эзэн бас явбал” гэж тэр хариулжээ.

“Гэхдээ хэрвээ би явбал, тэд намайг алж идэх болно” гэж Робинзоныг өчихөд,

“Үгүй, үгүй!” гэж Баасан орилоод, “Тэд таныг идэхгүй гэдгийг би батлая. Би тэднийг таныг маш их хайлрадаг болгоно. Би тэдэнд та хэрхэн дайснуудыг алж Баасангийн амийг аварсан тухай хэлнэ. Та надад сайн зүйлийг заасан. Та тэдэнд сайн зүйлийг заана” гэж хэлжээ.

Тэгээд Робинзон Баасанг дагуулан арлын нөгөө тал руу очиж олон жилийн өмнө тэнд нууж орхисон бяцхан завиа үзүүлжээ.

“За, Баасан, бид одоо танай үндэстэн рүү явах уу?” гэж Робинзоныг асуухад,

“Завь тийм хол явахад хэтэрхий жижиг байна” гэж хариулжээ.

Тиймээс Робинзон түүнийг дагуулан хэтэрхий хүнд, хэтэрхий арлын гүнд, усанд хүрэхэд хол байсан хамгийн анхны завин дээрээ аваачжээ.

“Энэ сайн том байна, гэхдээ усанд явахад сайн биш байна” гэж Баасан хэлжээ.

“Тийм ээ, Баасан” гэж Робинзон санал нэгдээд, “Энэ завь энд хорин гурван жилийн турш хэвтэж байгаа юм. Нар үүнийг хатааж хэсэг болгон цуулжээ. Хэрэглэхэд хэтэрхий өмхөрсөн байна. Гэхдээ бид өөрсөддөө шинийг хийж чадна” гэж хэлжээ.

Тэгээд Робинзон Баасан хоёр завиндаа хэрэглэх том модыг хайхаар болжээ. Энэ удаад, Робинзон голын цутгалантай ойролцоо мод олохыг зорьсон бөгөөд тэгснээр түүнийг ус руу аваачихад дөхөмтэй байх байлаа.

Робинзон Баасан хоёр хамтдаа ажиллаж завиа сарын дотор бэлэн болгожээ. Гэхдээ түүнийг өнхрүүлгээр эрэг рүү инч инчээр дөхүүлэн аваачихад дахиад хоёр долоо хоног шаарджээ.

Дараа нь Робинзон шулуун залуу хуш модыг цавчин унагаад шураг хийж өөр нэг арай жижиг модыг тайрч залуурын хэлбэрт оруулжээ. Тэрээр Баасанд туйлуудыг хэрхэн тааруулж хэлбэр гаргахыг харуулаад өөрөө далбаа хийхээр төлөвлөжээ.

Хуучин далбайн ямар ч хэсэг байсан одоо хорин долоон жилийн настай бөгөөд их өгөршсөн байлаа. Гэхдээ Робинзон бусад шигээ муудаагүй хоёр хэсгийг олжээ.

Тиймээс тэр тэднийг холбохоор ажиллаж эхэлсэн байна. Далбаа бэлэн болоход ойролцоогоор хоёр сарыг зарцуулжээ.

Далбааг шурганд бэхэлсний дараа залуун байрандаа байсан бөгөөд Робинзон завины анхны томоохон туршилтыг хийхэд бэлэн болсон байлаа.

Баасан Робинзоныг залуурыг хөдөлгөснөөр завийг аль ч чиглэлд залуурдаж байгааг гайхан харж зогсч байлаа. Баасан завийг хөдөлгөхийн тулд хэрхэн сэлүүрдэхийг л мэддэг байсан боловч бусад бүх зүйлийг сурдаг шигээ далбаатай завиар сэлэхийг хурдан сурчээ.

Энэ бол Робинзон арал дээр ирсний хорин долоо дахь жилийн ой байлаа. Тэдгээр бүх жилүүдэд анх удаагаа тэр календар дээр дахиад нэг жилийн хэрчлээс гарахаас өмнө арлыг орхин явж чадна гэдэгтээ маш ихээр итгэлтэй болсон байсан юм.



# 10-р бүлэг

## Каннибалууд эргэн ирэв

Завь бэлэн болмогц борооны улирал эхэллээ. Тиймээс Робинзон аялалдаа гарахаасаа өмнө нэг, хоёр сар хүлээхээр шийджээ. Түүнээс гадна тэр цаг хугацаа нь тэдэнд бэлтгэлээ базаахад хэрэгтэй байсан юм. Талх барих, мах хатаах, усан үзэм түүх, зэр зэвсгээ зэхэх хэрэгтэй байсан юм.

Нэг өдөр Робинзон эдгээр ажлуудаа хийгээд завгүй байх зуур Баасан яст мэлхийн өндөг цуглувулж байсан эргээсээ түүн рүү гүйн иржээ.

“Эзэн минь! Өө Эзэн минь! Өө уй гашуу! Өө муу зүйл!” гэж тэр орилж байлаа.

“Юу болоо вэ?” гэж Робинзон асуув.

“Тээр тэнд, тэнд!” гэж Баасан орилоод далай руу заан “Нэг, хоёр, гурван завь. Тэд Баасангийн араас ирж байна. Тэд Баасанг бариад жижиг хэсгүүд болгон хуваагаад түүнийг идэх болно” гэж хэлжээ.

“Бид хамтдаа тулалдах болно, Баасан. Хэрвээ чи миний дэргэд байж намайг хамгаалах юм бол би чамайг хамгаалах болно” гэж Робизон хэлжээ.

“Өө Эзэн минь, би тулалдана, би буудна, та намайг үх гэж хэлвэл би үхнэ” гэж Баасан уйлж байлаа.

“Баярлалаа, наиз минь” гэж Робинзон хэлээд дурангаа авч уулын хажуу руу авирч гарав. Дуран гурван завинд сууж явсан хорин нэгэн зэрлэг болоод гурван олзлогдогчийг тэр даруй илрүүлэв. Тэд ойн зах эрэг дээр дуусдаг Робинзоны уулын яг доорх эрэг дээр газардаж байлаа.

Робинзон доош буугаад шувууны буунууд, бялттай буунууд болон гар буунуудаа авчээ. Тэгээд Баасанг дуудаад “Миний араас ойрхон дагаж яв, гэхдээ намайг тушаал өгөх хүртэл юу ч бүү хий!” гэж хэлжээ.

Тэд ойн дунд хүрээд том модны ард нуугдаж ажиглажээ. Зэрлэгүүд гал тойрон суугаад аль хэдийнээ олзлогдогсодынхаа нэгнийх нь махыг идэж байлаа. Өөр нэг олзлогдогч нь ойролцоо элсэн дээр хүлээстэй хэвтэж байв.

“Хараач, Эзэн минь!” гэж Баасан шивнээд, элсэн дээр байгаа олзлогдогчийн зүг заваа. “Цагаан сахалтай хүнийг хараач! Тэр манай үндэстэн дээр завиар ирсэн цагаан хүмүүсийн нэг нь байна” гэж Баасан хэлэв.

Робинзон дурангаа өргөж илүү сайн харав. “Тийм байна, Баасан, энэ цагаан хүн байна! Тэр хувцас өмссөн байна” гэж тэр уулга алдav.

Робинзон хилэгнэсэн байлаа. Тэр Баасан руу дохиж хамтдаа ойн захтай ойролцоо мод руу чимээгүй дөхөж очжээ. Тэдэнд алдах хугацаа байсангүй. Учир нь зэрлэгүүдийн хоёр нь бусдаасаа салж цагаан хүн рүү чиглэж байлаа. Тэдний аварга модон сэлэм нь өргөгдөж түүнийг зоогондоо цавчиж хэдэн хэсэг болгоход бэлэн болсон байлаа.

“Одоо, Баасан” гэж Робинзон шивнээд, “яг миний хийж байгааг хийгээрэй!” гэж хэлэв.

Робинзон бялттай буугаа өргөж онилоод галлажээ. Робинзон буудлага нэг зэрлэгийг алж, хоёрыг нь шархдуулжээ. Баасан илүү сайн онилоод хоёрыг алж, дахиад гурвыг шархдуулжээ.

Үлдсэн зэрлэгүүд хөл дээрээ үсрэн боссон боловч аль зүг рүү харах, эсвэл гүйхээ мэдэхгүй байлаа. Тэд хаанаас энэ үхэл сүйрэл ирээд байгааг мэдэх аргагүй байлаа.

Баасан Робинзоныг анхааралтай ажиглаж дараагийн тушаалаа өгөхийг нь хүлээж байлаа. Робинзон бялттай буугаа орхиод шувууны буугаа авахад Баасан яг адил дагаж хийв.

“Галлаад!” гэж Робинзон ориллоо.

Тэдний шувууны буу нь галласан үед тал бүр тийш цацараг жижиг гар бууны сумаар цэнэглэгдсэн байжээ. Тиймээс тэд зөвхөн хоёр зэрлэгийг алсан байсан ч зөндөө олныг шархдуулж чадсан байжээ. Зэрлэгүүд одоо өөрийн цусандaa хутгалдаж яг л галзуу амьтад шиг орилж хаширэн гүйлдэж байлаа.

“Одоо, Баасан, өөрийн нөгөө бялттай буугаа гаргаад намайг дагаад яв!” гэж Робинзон модноос гүйж гараждаа дуудав.

Зэрлэгүүд тэднийг хармагц тэд газарт айн унацгаажээ. Гэхдээ тав нь үсрэн босч далайн зүг айн зугтаав. Баасан тэднийг завиндаа хүрэх үед нь галлаж эхлэхэд тэд тавуулаа унацгаав.

Энэ зуур, Робинзон эрэг дээр хүлээстэй байсан олзлогдогчийн зүг гүйж байлаа. Тэр хутгаа сугалан тэр хүний олсыг нь таслав. Дараа нь тэр айсан хүнийг өргөж босгоод Робинзон Португаль хэлээр хэн гэдгийг нь асуужээ.

Тэр хүн их ядарч айсан байсан болохоор зогсч, бас ярьж ч чадахгүй байлаа. Робинзон жижиг лонхтой ром дарс уутнаасаа гаргаад тэр хүнд амсуулав.

Түүний хэсэг хүч чадал нь эргэн ирэхэд тэр хүн Робинзоны асуултанд хариулжээ.

“Эспагнол” гэж тэр хэлжээ (“Испани хүн”)

Робинзон өөрийн мэдэх жаахан Испани хэлээрээ дараа нь ярилцъя гэж хэлжээ. Гэхдээ одоо тэд тулалдах хэрэгтэй байлаа.

Тэр хүн тулалдах хангалттай хүчтэй болсон гэдгээ удаанаар тайлбарлаж Робинзоны санал болгосон гар буу, сэлмийг нь авав. Гартаа зэвсэг барих мэдрэмж тэр хүнд шинэ хүч чадал өгсөн мэт санагдаж байлаа. Тэрээр зэрлэгүүд рүү нисэн очиж хоёрыг нь сэлмээрээ хэсэг хэсэг болгон тавчиж хаяжээ.

Дараа нь өөр нэг зэрлэг Испани эр лүү аварга модон сэлмээ эргүүлсэн ирэхэд Робинзоны харсан хэнээс ч илүү зоригтой тэр Испани эр зэрлэгтэй удаан тулалдав. Тэр зэрлэгийн толгойд хоёр цавчилж хийв. Тэгтэл түүнээс илүү том, хүчирхэг биетэй тэр зэрлэг түүнийг газар унагаад гараас нь сэлмийг нь салгаж авахаар оролдож байлаа.

Робинзон шувууны буугаа шүүрч аваад газар унасан хүний зүг гүйж эхэлжээ. Гэвч хормын зуур зоригт залуу бүснээсээ гар буугаа сугалан авч зэрлэгийг толгойд нь бууджээ.

Бүх тулаан дуусах үеэр зэрлэгүүдийн арван долоо нь алагдсан байлаа. Амьд гарсан дөрөв нь завиндаа сууж далай руу хурдтайгаар сэлүүрдэн холдож байв.

Баасан эрэг рүү гүйн очиж “Бид дагана, бид дагана. Зэрлэгүүдийг үндэстэн рүү нь буцааж явуулж болохгүй. Тэднийг олон зуун бусдыгаа дагуулан ирэхийг нь зөвшөөрч болохгүй” гэж орилж байлаа.

Робинзон санал нэгдэж завинуудын нэгэнд нь үсрэн ороход гайхалтай нь тэнд өөр нэг олзлогдогч уугул, гар хөл нь хүлээстэй хэвтэж байлаа.

Робинзон түүнийг чөлөөлж Баасанг дуудаад тэр айсан хүнд аврагдсан гэдгийг нь тайлбарлаж өг гэж хэлэхэд Баасан завин дээр гараад үхсэн юм шиг хөдөлгөөнгүй зогсов. Тэр нүдэндээ итгэж чадахгүй байлаа!





## 12-р бүлэг

# Аралд Англичууд ирсэн нь

Найман өдрийн дараа нэгэн өглөө Робинзон Баасангийн дуудлагаар сэргээ.

“Эзэн минь, Эзэн минь! Тэд ирлээ, тэд ирлээ!” гэж тэр орилж байлаа.

Робинзон үсрэн босч майхнаасаа гүйн гарав. Түүний нүд тэнгисийг харуулдаж гурван милийн зайд байгаа завийг олж үзэв. Гэвч тэр завь эх газраас ирж байгаагүй юм.

“Эргээд ир, Баасан!” гэж тэр дуудаад, “Эд нар бидний хүлээж байгаа хүмүүс биш байна. Бид тэднийг нөхөр үү, дайсан уу гэдгийг мэдэхгүй” гэж хэлэв.

Робинзон тэр даруй дурангаа авч ирээд уулын өөд авирч гарав.

Оройд гараад тун удалгүй тэрээр зүүн өмнө зүгт зургаан миль орчимд зангуугаа буулгасан хөлөг онгоц байгааг олж үзжээ. Английн хөлөг онгоц гэж харагдаж байсан бөгөөд эрэг рүү чиглэж яваа жижиг завь нь худалдааны хөлөг онгоцонд байдаг урт завь нь байлаа.

Робинзон өөрийн улсын хүмүүстэй завийг хараад хөл нь газар хүрэхгүй баярлаж байлаа. Гэвч тэр бас санаа зовж байлаа, учир нь Английн хөлөг онгоцууд дэлхийн энэ хэсэгт ихэнхдээ худалдаа хийдэггүй байжээ. Хөлөг онгоцыг энд авч ирэх ямар ч хар салхи ойрдоо болоогүй байлаа. Тиймээс Робинзон тэр хөлөг онгоцыг яагаад ирснийг олж мэдэх хүртлээ өөрийгөө нуухаар шийджээ.

Урт завь эрэгт ойртох ирэх үед давалгаа орж ирж байсан тул далайчид завиа эрэг дээр гаргажээ. Робинзон тавцан дээр арван нэгэн хүн байгааг харсан боловч тэдний гурав нь гар хөл нь хүлээстэй харагджээ.

Далайчид завинаас үсрэн бууж гурван олзлогдогчоо бас татаж буулгав.

Эрэг дээр буучихаад тэдний уяаг нь тайлж гэнэ. Нэг олзлогдогч нь өвдөглөн суугаад далайчдын нэгнээс нь ямар нэгэн юм гүйж байгаа харагджээ. Тэр далайчин түүнийг түлхэж орхиж гэнэ.

Дурангаар бас харж байсан Баасан “Өө Эзэн минь! Англичууд яг зэрлэгүүд шиг олзлогдогсодаа иддэгийг та харлаа” гэж дуудахад

“Үгүй ээ, Баасан, Би тэднийг олзлогдогсодаа алах болов уу гэж бодож байна, тэднийг идэхгүй гэдэгт чи итгэлтэй байж болно” гэж Робинзон хариулжээ.

Робинзон гурван Англи хүн алуулах гэж байгааг хараад чичрэн зогсч байлаа. Тэр тэднийг аврахаар оролдох хэрэгтэй байсан юм.

Хэдэн минутын дараа далайчдын зургаа нь арлыг шинжлэхээр явах үед түүнд боломж гарчээ. Гурван олзлогдогч урт завин дотор ром дарс ууж байгаа хоёр далайчнаас өөр ямар ч хамгаалалтгүй үлджээ. Гэвч олзлогдогсодад ямар ч зугтаах газар байсангүй, тиймээс тэд модны доор ойн захад суугаад бие биерүүгээ цөхрөнгүйгээр харж байлаа.

Робинзон Баасан хоёр хангалттай харсан байв. Тэд уулнаас бууж шувууны буу, бялттай буу болон гар буунуудаа цэнэглэж эхлэв. Тэд уутнуудаа нэмэлт сум болон дариар дүүргэжээ.

Зургаан далайчин эргэж ирээгүй болоод нөгөө хоёр нь завин дотор унтчихсан, эсвэл согтоод уначихсан байгааг харсан Робинзон Баасан хоёр уулаас бууж

олзлогдогсод руу чиглэж явав. Тэд олзлогдогсодын ард чимээгүй очоод Робинзон тэдний анхаарлыг “Чи хэн бэ, ноёнтоон?” гэж зөвлөн дуудаж татжээ.

Тэр залуус ганцхан тэр хачин жигтэй хоолойн чимээнээс бус, мөн Робинзоны дүр төрхнөөс цочицгоов гэнэ. Тэрээр ямааны арьсан хувцас болон гартаа барьсан бүх зэвсгийнхээ хамт маш ширүүн хэрцгийн харагдаж гэнэ. Залуус юу ч хэлсэнгүй, харин түүн рүү дайрахад бэлэн байгаа юм шиг санагджээ.

Тэгээд Робинзон дахин ярьж “Ноёд оо, намайг хараад буу гайхацгаа. Би бол нөхөр, магадгүй та нарт тусалж чадах байх” гэж өгүүлэхэд,

“Чи бол диваажингаас шууд илгээгдсэн сахиусан тэнгэр байх ёстой. Гэвч одоо бидэнд хэн ч тусалж чадахгүй” гэж тэдний нэг нь хэлэв.

Робинзон инээмсэглээд “Хэрвээ бурхан чамд туслах гэж сахиусан тэнгэр илгээсэн бол тэр сахиусан тэнгэр арай илүү сайхан хувцасласан байх байсан. Бүү айтгун. Би Англи хүн байна. Энэ бол миний хүн, Баасан. Бидэнд зэвсэг хэрэгсэл байна, тиймээс бид тусалж чадаж магадгүй” гэж тайлбарлав.

Тэр залуусын нэг нь босч зогсоод “Би тэр далайд зангуугаа хаяд зогсох хөлөг онгоцны ахмад нь байсан юм. Миний хүмүүс миний эсрэг бослого гаргаж хөлгийг маань булаан авсан. Эхлээд, тэд намайг хороох гэж байсан юм. Гэхдээ дараа нь тэд намайг энэ эрэг дээр анхны хамтрагч болоод миний зорчигч байсан энэ ноёнтой хамт үлдээхээр шийдсэн билээ. Бид энд үхнэ гэдэгтэй итгэлтэй байна. Учир нь бид энэ арал дээр хэн нэгэн амьдардаг гэж хэзээ ч зүүдэлж байгаагүй юм байна” гэж тайлбарлав.

“За байз, Баасан бид хоёр, гэхдээ дараа нь өөр бас олон хүн” гэж Робинзон хэлээд завинь зүг дараагаар нь ойн зүг харав. “Хэн ч биднийг хараахан мэдээгүй байна, гэхдээ бид боломжийг алдаж болохгүй. Намайг хурдан дага!” гэж тэр хэлэв.

Робинзон эрчүүдийг ойн гүн рүү дагуулан явжээ. Тэд аюулгүй нууц газар очоод Робинзон ахмад руу хандаж ийн асуув, “Эрхэм ээ, хэрвээ би таныг эндээс оргоход тусалж бас хөлөг онгоцыг тань буцааж авч өгвөл та миний төлөө хоёр зүйлийг хийхэд бэлэн байна уу?”

“Би чиний асуусан юу ч бай, хийе эрхэм ээ. Миний хөлөг онгоц болоод би чиний удирдлагын дор байх болно. Мөн би чамд бүх насаараа үнэнч явахаа андгайлъя” гэж түүнийг хэлэхэд нөгөө хоёр залуу ч мөн зөвшөөрч толгой дохицгоов.

“Сайн байна. Гэхдээ та нар бас энэ арал дээр байх хугацаандaa миний тушаалыг дагах ёстой гэдэгтэй санал нийлэх хэрэгтэй. Тэгээд дараа нь хэрвээ бид таны хөлгийг бцааж авч чадвар, та намайг болон миний хүн Баасанг Англи руу ямар ч хөлсгүйгээр авч явахаа амлах хэрэгтэй” гэж Робинзон хэлэв.

“Чамд амлаж байна” гэж ахмад хэлэв.

“Сайн байна” гэж Робинзон хэлээд “Одоо эдгээр босогчдын эсрэг дараах алхмаа төлөвлөцгөө” гэв.

Хөлгийн ахмад болдог бол өөрийн хүмүүсийн хэнийг нь ч хороомооргүй байсан бөгөөд мөн тэднийг арлыг орхин явж хөлөг дээр байгаа бусаддаа анааруулга өгөхийг нь хүсэхгүй байсан юм.

Робинзон түүнд яг хариулах гэж байтал тэд ойн дундуур буцан ирж байгаа далаичдыг сонсчээ. Робинзон өөрийн хүн бүртээ нэг нэг буу бөгөөд хамтаддаа далаичдыг отжээ.

Эхний хоёр нь буудуулж үхэхэд бусад аюулд орсноо мэдээд өршөөл эржээ. Хөлгийн ахмад хэрвээ тэд түүнд үнэнч байж хөлгөө буцааж авахад нь туслахаа

амлах юм бол амийг нь өршөөнө гэж хэлжээ. Тэдгээр хүмүүс үнэнч байхаа амлаж ахмад тэдэнд итгэв. Тэр тэдний амийг нь өршөөсөн боловч Робинзоны шаардлагаар гар хөлийг нь хүлэв гэнэ.

Завин дээр байсан хоёр цэрэг буун дуу гарахыг сонсоод ой мод руу гүйн иржээ. Тэд юу болсныг үзээд бууж өгч мөн хүлүүлэв.

Робинзон Баасан хоёр хүмүүсийг цайз руу аваачжээ. Тэд олзлогдогсодаа агуид оруулж орхиод дараагийн алхамаа төлөвлөхөөр сууцгаав гэнэ.

“Бид юу хийж чадахыг би мэдэхгүй байна, учир нь тэнд хөлгийн тавцан дээр хорин зургаан хүн байгаа. Тэд бослогын шийтгэл дүүжлүүлэх гэдгийг маш сайн мэддэг. Тиймээс тэд баригдахгүй байхын тулд зэрлэгээр тулалдах болно” гэж хөлгийн ахмад хэлэв.

“Би санал нэг байна аа, эрхэм ээ. Тэд бол аргаа барсан хүмүүс. Мөн бид тавуулаа тэр хорин зургаагийн эсрэг явна гэдэг бол бидний хувьд тодорхой үхэл болно. Үгүй, үгүй, бид илүү сайн арга олох хэрэгтэй. Бид тэднийг занганд унагах хэрэгтэй!” гэж Робинзон хэлэв гэнэ.



# 13-р бүлэг

## Робинзон бослогыг дарав

“Надад нэг санаа төрөх шиг боллоо” гэж ахмад хэлээд, “Мэдээж багийн олонхи нь эрэг дээр ирж нөхдөө хайх болно. Бид тэднийг эхлээд занганд оруулж болно, хөлөг онгоцоо дараа нь эргүүлж авна” гэв.

Тэр мөчид хөлгийн буу галлаж дохионы туг шурган дээр өргөгдөв гэнэ. Тэд урт завийг хөлөг рүү буцаж ирэхийг тушааж байгаа нь энэ юм. Буу дахин дахин буудаж байсан ямар ч завь гарч үзэгдсэнгүй гэнэ.

Эцэст нь өөр нэг завь доош буужээ. Робинзон дурангаараа бялт буугаар зэвсэглэсэн арван далайчин эргийг чиглээд сэлүүрдэж байгааг харжээ. Тэднийг ойртон ирэхэд ахмад тавцан дээрх хүмүүсийг танилаа.

“Тэр араваас гурав нь маш үнэнч нөхөд байгаа юм. Тэд энэ бослогод албан хүчинд автаж оролцсон гэдэгт би итгэлтэй байна. Харин хөлгийн удирдагч болоод бусад нь муухай, найдваргүй хүмүүс байдаг” гэж тэр хэлжээ.

Робинзон өөртөө итгэлтэй инээмсэглэж байлаа. “Эрхэмээ, бид таван хүн, дээр нь таны итгэдэг агуид байгаа хоёр олзлогдогчийг нэмээд долуулаа болно. Бид мэдээж тэр аравтай тулалдаж чадна, ялангуяа бид таны шударга гэж хэлсэн гурван хүнд итгэвэл бид ялж чадна” тэр хэлжээ.

Ахмад зөвшөөрч, Робинзон тэр хоёр олзлогдогчийг суллаж авчуулахаар Баасанг агуй руу явуулжээ. Хүн бүр зэвсэглэсний дараа Робинзон өөрийн таван хүний армия ойн гүн рүү дагуулан оров. Завь газардаж багийн гишүүд нь эрэг дээр зогсч байлаа. Тэд бүх чадлаараа орилж төөрсөн багийн гишүүдээ олохыг оролдож байв. Тэд хэд хэдэн удаа буудсан боловч ямар ч хариу хүлээж авсангүй. Эцэст нь далайчдын долоо нь уулсын гүн рүү эрлээ үргэлжлүүлэхээр орж гурван хүнийг завиа хамгаалуулж үлдээжээ.

Одоо, шинэ асуудалтай Робинзон тулгарлаа. Хэрвээ тэр эрэг дээр долоон хүнийг баривал нөгөө гурва нь мэдээж хөлөг рүү буцаж зугтах байлаа. Тэгвэл ахмад хэзээ ч хөлгөө буцааж авч чадахгүй, мөн Робинзоны арлаас явах итгэл нь балрах байлаа.

Робинзон хэсэг зуур бодосны эцэст хариултыг нь олжээ. Тэр арал дээрх далайчдыг хуваах байлаа. Тэгээд эрэг дээр үлдсэн гурван хамгаалагчийг баривчилж завийг нь авах байлаа.

Тэр Баасанд болон эрчүүдийн хоёрт нь арал дээр өөр өөр зүгт тарж яв гэж хэлжээ. Тэд дуу хоолой нь цуурайтах ууланд очоод хамгийн чангаараа “Хелло!” гэж орилох байлаа. Далайчид энэ дууг нь сонсоод арлын гүн рүү явж ороод тал тал тийш тарах байлаа. Далайчид тэр хоолойг мэдээж өөрийн хөлгийн нөхдийн дуу гэж бodoх байсан юм.

Баасан болоод түүний залуус тарж удалгүй далайчдыг эргээс миль хэртэй холдуулж голын цутгалангийн ойролцоо аваачжээ. Давалгаа өндөр байсан болохоор далайчид гаталж чадахгүй байлаа. Тиймээс тэд хамгаалагч нарыг завиа авч ир гэж дуудсан юм. Гурван хамгаалагч завийг голын цутгалан дээр авч ирж хүмүүсээ гатлуулаад хоёр нь завиа харж үлдээд гурав дахь нь эрэлд нэгджээ.

Энэ бол яг Робинзоны итгэж байсан зүйл юм. Далайчид үзэгдэхээ больмогц Робинзон болон түүний хүмүүс хоёр балмагдсан хамгаалагч руу довтолжээ. Цөөдсөн гэдгээ мэдээд тэд тэр даруй бууж өгсөн байна. Ахмад тэднийг хараад өмнө ярьж байсан үнэнч хүмүүсийн хоёр нь байна гэдгийг таньжээ. Эдгээр хүмүүс ахмадтай эргэн нэгдэж түүний төлөө босогчдын эсрэг тулалдахаа баяртай байлаа.

Баасан болон түүний хүмүүс түүний дараа удалгүй эргэн ирж даалгавар амжиллтай болсныг мэдэгдэв.

Тэд далайчдыг ой мод руу маш гүн оруулсан тул тэд тэндээ төөрч ядраад харанхуй болохоос өмнө голын цутгалан руу эргэж ирж чадахааргүй болсон гэжээ. Тэгээд харанхуй бол Робинзоны төлөвлөгөөгөө амжилтанд хүргэхэд хэрэгтэй байсан цор ганц зүйл нь юм.

Шөнө болоход найман залхаж гомдоллосон далайчид голын цутгалынгийн эрэгт ирэхэд завь тэнд байжээ. Гэвч хоёр хамгаалагч нь алга байлаа. Далайчид алга болсон хоёр хөлгийн нөхдөө дуудахаар өөр чиглэлд явжээ. Тэд энэ хоёрдахь ор сураггүй алга болж байгаа явдлыг хараад гайхширч гүйцээд байлаа.

Робинзон болон түүний залуучууд далайчдыг ой модон дахь нууц газраасаа сэм харж байсан бөгөөд бослогын удирдагч ахмадын нуугдаж байсан том хаданд ойртож ирэхэд ахмад үсрэн гарч ирээд бууджээ. Гэмт босогч тэр газраа үхэдхийн унав.

Робинзон өөрийн армийг дахин нэгтгэж тэд харанхуйд далайчдын бусдыг нь бүсэлж авчээ.

Робинзон өөрийн нэг хүнээрээ тэднийг дуудуулан бууж өгөх тухай ярилцуулжээ.

“Том Смит! Том Смит!” гэж тэр хүн дуудаж байсан бөгөөд Смит тэр даруй “Энэ чи юу, Уиллиамс?” гэж хариулжээ.

“Тийм ээ, тийм! Бурханыг бодоод, Смит, зэвсгээ хаяаад яг одоо бууж өг, эсвэл та нар бүгдээрээ үхэх болно!”

“Бид хэнд бууж өгөх ёстой вэ? Бас тэд хаана байна вэ?” гэж Смитийг асуужээ.

“Манай ахмад энд тавин хүний хамт байна. Бид та нарыг хоёр цагийн турш ангуучилж байна. Бас бид та нарыг бүсэлсэн байгаа. Танай удирдагч алуулсан, би одоо олзлогдогч болсон” гэж Уиллиамс хэлжээ.

“Бид бууж өгвөл тэд бидний амийг аврах болов уу?” гэж Смитийг асуухад,

Ахмад түүнд хариулж, “Смит, чи миний хоолойг мэднэ. Хэрвээ чи зэвсгээ буулгаж нэн даруй бууж өгвөл, амийг чинь өршөөнө, Уилл Аткинсээс бусдынх нь амийг өршөөнө. Учир нь түүнд ямар ч өршөөл байхгүй” гэж хэлэв гэнэ.

Үүнийг сонссон Уилл Аткинс орилж “Бурхныг бодож, ахмад аа, намайг ч бас өршөөгөөч. Би эд нарын хийгээгүй юуг хийчихсэн юм бэ?” гэхэд,

“Бослого эхлэхэд над руу довтолсон хүн бол чи, Аткинс. Би чамайг огтхон ч өршөөхгүй. Чиний цорын ганц найдвар бол энэ арлын захирагч чамайг өршөөж амийг чинь хэлтрүүлэх явдал” гэж ахмад хэлэв.

Робинзон модны ардаас чимээгүй инээд алдав. “Тиймээ, Би энэ арлын захирагч нь юм шиг байна” гэж тэр өөртөө хэлэв. Гэвч түүнд шинэ цолоо таашаах цаг байсангүй. Далайчид зэвсгээ буулгахад Робинзон гурван хүнээ илгээж тэднийг хүлүүлжээ.

Робинзон олзлогдогсодад үнэндээ тавин хүнтэй армигүй гэдгээ мэдэгдүүлэхгүй тулд өөрийн армидаа нуугдаж байхыг тушаажээ. Тэгээд тэр ахмад болон түүний хүмүүст олзлогдогсодыг агууд аваачихыг тушаасан байна.

Робинзон өөрийгөө ч мөн нууж байлаа. Олзлогдогсодад захирагч ямааны арьсан малгай, ямааны арьсан өмдтэй харагдах нь тийм ч мэргэн хэрэг биш байсан юм. “Тэд энэ нууцлаг захирагчийн тухай хүссэнээ л бодог. Намайг тэдний хувь тавиланг шийдэх үед тэдэнд намайг харах хугацаа хангалттай гарна “ гэж Робинзон бодож байлаа.

Агууд орсныхоо дараа олзлогдогсод бослогод хичнээн харамсаж буйгаа илэрхийлж уччал гүйгаад, дахин амийг нь өршөөхийг гүйжээ.

“Та нар миний олзлогдогсод биш, та нар энэ арлын захирагч, нэгэн Англи хүний олзлогдогсод. Тэр захирагч л дангаараа та нарыг энд дүүжлэх үү, эсвэл Англи руу буцааж тэнд шүүгээд, дүүжлэх үү гэдгийг шийднэ” гэж ахмад хүйтэн хөндий тайлбарлав.

“Гэхдээ та бидний төлөө захирагчтай ярьж өгч чадахгүй гэж үү?” гэж олзлогдогсодын нэг нь гүйжээ.

“Би оролдоод үзье, гэхдээ захирагч Уилл Аткинсийг өглөө үүрээр дүүжлэхээр аль хэдийнээ тушаал буулгачихсан байгаа” гэж ахмад хэлжээ.

Энэ бүх түүхийг ахмад зохиосон ч түүний хүлээж байсан үр нөлөөг авч ирж байлаа. Аткинс өвдөг сөгдөж амийг нь өршөөхийг гүйж эхэлжээ. Бусад нь Англи руу буцаагдахгүй байхыг гүйж байжээ. Учир нь дүүжлэх ял бослогод оролцсон бүх хүмүүст оногддог гэдгийг тэд сайн мэддэг байлаа.

“Шийдвэр зөвхөн мэргэн захирагчийнх байх болно. Яг одоо тэр арлынхаа нөгөө талд цайздаа, та нарын хувь тавиланг шийдээд сууж байгаа” гэж ахмад хэлэв.

Гэвч тэр мэргэн захирагч агуун гадна харанхуйд ямаагаад сууж байлаа!



# 14-р бүлэг

## Робинзон хөлөг онгоцыг эзэлсэн нь

Хөлгийн ахмад агууд байсан олзлогдогсодтай ярилцаж дуусаад гадна байсан Робинзонтой нэгдэж тэд одоо хөлөг онгоцыг хэрхэн эзлэн авах тухай төлөвлөгөө боловсруулах хэрэгтэй байлаа. Бүгд жижиг армия бүрдүүлсэн долоон эр хөлөг дээрх бусад босогчдыг ялахад хангалттай биш байсан гэдэгт санал нэгдэж байсан юм.

Тиймээс ахмад агууд руу буцан орж итгэж болохоор илүү олон хүнтэй болох хэрэгтэй байлаа. Тэрээр тэднийг амьд байгаа нь хичнээн азтай хэрэг болохыг сануулснаар яриагаа эхэлсэн юм. Мэдээж тэд дүүжлүүлэх ялтай байсан юм.

Олзлогдогсод гунигтайгаар толгой дохиж ахмад үнэнийг хэлж байгааг ойлгож байлаа.

“Гэхдээ, хэрвээ та нар надтай нэгдэж хөлөг онгоцоо буцаан авахад туслах юм бол та нар бүгдээрээ аврагдах болно гэсэн захирагчийн амлалт надад байгаа” гэж ахмад үргэлжлүүлэв.

Тэнд байсан хүмүүс амиа аврах боломж олдсонд ихэд баярлалдаж байлаа. Тэд өвдөг дээрээ сөгдөж үхэх өдрөө хүртлээ ахмадад үнэнч явахаа тангараглаж гэнэ.

“Би одоо цайз руу явах хэрэгтэй. Захирагчид та нар юу гэж амласныг дуулгана” гэж ахмад хэлэв.

Ахмад Робинзоны майхан руу очиж болсон яриаг дуулгажээ. Робинзон олзлогдогсодын зөвхөн тавыг нь л ашиглаад үлдсэн зургааг нь агуиг үлдээхээр шийджээ. Ингэснээр тэр тав нь амлалтаа биелүүлж үнэнчээр тулалдахгүй бол үлдсэн нөхдийг нь дүүжлэх юм.

Ахмад үүнийг олзлогдогсодад дуулгахад тэд захирагчийг маш хатуу чанга мөртлөө ухаалаг нэгэн гэдгийг ойлгожээ.

Одоо олзлогдогсод өөрсдөө нэг нэгнийгээ зоригтой, үнэнч тулалдах эсвэл дүүжлүүлэх эрсдлийг хүлээн авах тал дээр ятгаж эхэлжээ.

Ахмад арван нэгэн хүнийхээ хамтаар хоёр завинд суухад Робинзон Баасан хоёр үлдсэн олзлогдогсодыг харж үлджээ. Шөнө дунд болж байсан бөгөөд харанхуй тэдний үнэн төрхийг тавцан дээр гарах хүртэл нь нууж байлаа. Босогчид тэдгээр завиудад өөрсдийнх нь хүмүүс суугаад эргээс буцан ирж байна гэж бodoх байлаа.

Тавцан дээр гаралт болоод түүний хүмүүс довтолж эхэлжээ. Тэд тавцан дээр байсан хүмүүсийг хүч даван ялаад тавцангийн хаалгыг хааж доор байсан хүмүүсийг цоожилжээ.

Дараа нь тэд ахмад болоод байгаа босогчийн бүхээг рүү дайран оржээ. Нааш цааш их буудалцсаны эцэст босогчдын ахлагч газар үхэдхийн унаж түүний эргэн тойронд байсан хүмүүс нь шархдсан байлаа.

Ахлагч нь үхсэнийг хараад бусад нь бууж өгөв. Бослого дууссан байлаа, тэгээд хөлөг одоо жинхэнэ ахмадынхаа гаралт эргэн орсон байв.

Ахмад Робинзонд дайралт амжилттай болсныг мэдэгдэх долоон буу буудах тушаал буулгав. Эрэг дээр хоёр цаг хүлээсний эцэст Робинзон бөөн баяр болов.

Үүр цайх үед ахмад арал дээр эргэн ирлээ. Тэрээр Робинзоныг удаан гэгчийн тэвэр завь руу заагаад “Хайрт найз болоод аврагч минь, тэнд чиний хөлөг онгоц байна. Тэр бүгд чинийх, би ч, манай хүмүүс ч бас чинийх” гэх хэлжээ.

Робинзон харуулдаж үзэхэд голын цутгалангийн төгсгөлд түүний завь нь зогсч байлаа. Түүний туг нь намирч, далбай нь дэлгээстэй байв. Тэр түүнийг гэр лүү аваачихад бэлэн байлаа.

Робинзон ганц үг хэлж чадсангүй. Баяр баясал нь түүнийг хэдэн минутын турш хэлгүй болгожээ. Тэгээд, эцэст нь, нулимын гарч иржээ.

Робинзон ахмадын гарыг барьж мэгшин уйлаад, “Найз минь, чи үнэхээр намайг аврахаар диваажингаас ирсэн ажээ!” гэж хэлээд өвдөглөн сууж бурханд талархлын залбирил өргөжээ.

Энэ баярт явдлыг тэмдэглэхийн тулд ахмад захирагчид хэсэг бэлэг авч ирсэн байлаа. Тэр эдгээрийг цайз руу аваачихаар өөрийн хүмүүсээ дууджээ. Тэнд хайрцаг хайрцгаар дарс, шуудай шуудайгаар мах, хайрцаг хайрцгаар жигнэмэг, сагс сагсаар хүнсний ногоо, зах захаар хувцас оймс гутлын хамт иж бүрэн байлаа.

Робинзон маш их, ялангуяа хувцсанд маш их баярлажээ! Гэвч түүнийг өмсөх нь өөр түүх байлаа. Учир нь арван найман жилийн турш огт өмсч үзээгүй цамц, өмд, малгай, оймс, гутал өмсөх нь ихээхэн тухгүй байлаа.

Робинзон ойр орчимд хэсэг зуур алхаж шинэ хувцсандaa дасах гэж оролджээ. Тэр болон ахмад цуг сууж хөлгийг эзлэх үед олзолсон хүмүүсийг яах тухай ярилцав.

Хоёроос бусад нь тайван бууж өгсөн байлаа. Гэхдээ тэр хоёр асуудал болж болох байлаа.

“Бид тэднийг Англи руу гинжлээд авч явж болох юм. Гэхдээ тэд хөлгийн тавцан дээр дахиад л асуудал үүсгэнэ гэж аиж байна” гэж ахмадыг хэлэхэд,

“Тэгвэл яагаад тэднийг энд , арал дээр үлдээж болохгүй гэж? Тэд мэдээж яг над шиг амьд үлдэж чадна” гэж Робинзон санал тавьжээ.

Ахмад зөвшөөрч Робинзон Баасан хоёр тэр хоёрыг авч ирэв. Шинэ хувцасаа өмссөн Робинзон арлын захирагч шиг л гайхалтай харагдаж байлаа. Олзлогдогсдыг орж ирэхэд Робинзон тэднийг удаан нарийн ажиглаад, “Би та нарын бүх муу үйлийн тухай найз ахмадаасаа сонссон. Та нар хэрхэн түүний хөлгийг булаан зугтаад, мөн бусад хөлөг рүү довтлохоор төлөвлөж байсныг чинь би мэдсэн. Гэхдээ та хоёр ахлагч чинь шийтгэл хүлээсний нэгэн адил шийтгэл хүлээх хэрэгтэй.

Хөлөг рүүгээ хараач, адгийн амьтад аа! Тэнд дүүжлээстэй үхсэн ахлагчаа хар! Би та нарыг далайн дээрэмчин шиг шийтгэх хэрэгтэй юу? Захирагчийн хувиар, надад тэгэх эрх бий, та нар үүнийг мэдэх хэрэгтэй!” гэж Робинзон хэлжээ.

Тэдний нэг нь хариуд нь, “Эрхэм дээдэс минь, бидний өршөө” гэж гуйхад Робинзон “За байз, би та нарт ямар өршөөл үзүүлэхээ мэдэхгүй байна. Учир нь би энэ арлаас бүх хүнээ аваад явахаар зэхэж байгаа. Би ахмадтай хамт Англи руу явж байгаа. Тэгээд та нарыг хамт авч явбал та нар хоригдлын хувиар төмөр гинжинд явах болно. Тэгээд, бид Англид очиход та нар урвалт, бослогын хэргээр шүүгдэж үр дүнд нь мэдээж дүүжлүүлнэ. Тиймээс, Та хоёр энд амьдрахаар оролдож үзэхгүй л бол би та нарт яг юу хамгийн тохиромжтойг үнэхээр мэдэхгүй байна. Би нэгэнт явж байгаа учраас надад хамаагүй” гэж хэлэхэд,

“Өө, танд баярлалаа, Эрхэм дээдэс ээ” гэж тэр залуу уйлж байлаа. Тэд хоёулаа Англид очиж дүүжлүүлж байснаас арал дээр үлдэхийг илүүд үзэж байлаа. Тэгээд Робинзон дахин аллага гаргахыг хүсэхгүй байсан учраас тэднийг үлдэхийг нь зөвшөөрчээ.

Тэр хүмүүс олсноосоо чөлөөлөгдхөд Робинзон хэдэн цагийн турш тэдэнд өөрийн хорин найман жилийн турш арал дээр хэрхэн амьдарч байснаа тайлбарлаж өгчээ. Тэр тэдэнд хэрхэн цайз барьснаа, хэрхэн газар хагалж, эрдэнэшиш тариалснаа, хэрхэн эрдэнэшишээ хурааж, хэрхэн шавар эдлэл хийн, хэрхэн сагс сүлжиж, хэрхэн үзэм хатааснаа, хэрхэн талх барьснаа, хэрхэн ямаа сааснаа болон хэрхэн тос, бяслаг хийж чадсанаа тайлбарлаж өгчээ. Ерөнхийдөө бол тэр тэдэнд арал дээр амьд үлдэхэд нь мэдэх хэрэгтэй бүхнийг зааж өгчээ.

Тэр мөн тэдэнд арал дээр тун удалгүй ирэх гэж байсан Испаничуудын тухай хэлж тэр хоёр залууг шинээр ирэгсдэд эелдэг хандах амлалт өгүүлэв.

Робинзон тэдэнд бүх зэвсгээ үлдээгээд хөлөг онгоц хөдлөхөөс өмнө нэмэлт сум авч өгнө гэж амлажээ.

Тэгээд Робинзон арал дээрх өөрийн сүүлчийн оройгоо замын дагуу алхаж олон жилийн турш мэдэх болсон ууланд авирч өнгөрөөжээ.

Дараа өглөө нь ахмад Робинзон болон Баасанг авахуулахаар эрэг рүү завь илгээв. Робинзон явахад бэлэн болоходоо өөрийн ямааны арьсан малгай, ямааны арьсан шүхэр, totty, агуид олон жил байж зэвэрч, өнгөө алдаж эхлээд байсан бүх алт мөнгөө авч гарчээ.

Тэгээд түүний календарийн шон дээрх хэрчлээсийн дагуу Робинзон арлаа 1686 оны арван хоёрдугаар сарын 19-нд орхижээ. Энэ нь түүнийг ирснээс хойш яг хорин найман жил, хоёр сар, есөн өдрийн дараа болсон юм.



## 15-р бүлэг

# Дахиад гэртээ

Далай дахь зургаан сарын урт аяллынхаа дараа Робинзон 1687 оны зургадугаар сарын 11-нд Англид буцаж иржээ. Тэр гучин таван жилийн турш явж байгаад ирсэн юм.

Тэрээр тэр даруйдаа Йоркшайр дахь гэр лүүгээ явсан боловч ээж, аавыгаа нас бараад олон жил болж байгааг олж мэджээ. Гэхдээ тэр эгч нарынхаа хоёрыг нь олж чадсан бөгөөд нас барсан ах нарынхаа хүүхдүүдийг мөн олж мэджээ.

Дараах долоон жил нь Робинзон Англи Португаль хоёрын хооронд аялж Бразил дахь тариалангийнхаа бизнесийн асуудлуудыг зохицуулахаар оролдсон байна. Тариалан нэллэн амжилттай болсон байсан бөгөөд Робинзоны хариуцуулж үлдээсэн шударга хүн нь маш ухаалгаар удирдаж байжээ. Тэнд Робинзонд зориулж хадгалсан их хэмжээний мөнгө байсан бөгөөд тэр мөнгийг Англид байхад нь илгээхээр зохицуулсан байна.

Тэр олон удаа Бразиль руу буцаж тэндээ амьдрах тухай бодож байсан боловч дараа нь ингэхгүйгээр шийджээ. Тэрээр тариалангаа тэндэхийн хоёр хөршдөө зараад Англид суурьшсан байна.

Робинзон нас барсан ахынхаа хоёр хүүг асран халамжлах болсон бөгөөд тэдний нэг нь хууль судалж нөгөө нь Робинзон далайн амьдралын мөрөөдлийг өвөлж авсан юм шиг санагдаж байлаа.

Робинзон түүнийг хөлөг онгоцон дээр ажиллуулахаар болсон бөгөөд таван жилийн дараа тэр хатуу чанга далайчин, амжилттай худалдаачин гэдгээ баталж чаджээ. Тиймээс Робинзон түүнд зориулж хөлөг онгоц тоноглож өгсөн бөгөөд өөр нэгэн Крузо ингэж худалдаачин, далайчин болсон юм.

Залуу хүү Испанид хийсэн хэд хэдэн амжилттай худалдаанаас эргэж ирснийхээ дараа Робинзоныг түүнтэй дараагийн аялалд нь нэгдэж хамт явахыг ятгажээ. Энэ удаагийнх нь Өмнөд Африк руу явах байлаа.

Робинзон шинэ адал явдлын сэтгэлийн хөөрлөө барьж чадахгүй байлаа. Тэр болон Баасан хоёр одоо газар дээр найман жил болж байгаа билээ.

Энэ аялалд Робинзон өөрийн арал дээрээ дахин зочилсон байна. Тэр өөрийн үлдээсэн хоёр олзлогдогч нь ясан тухай, мөн хүлээж байсан Испани эр нь ясан тухай мэдэхийн хүсэл болж байлаа. Тэнд Англичууд болон Испаничууд найрамдалтайгаар хамтран амьдарч байгааг харжээ. Тэд үнэндээ арлыг тариаланд ашиглах болоод колончилж байсан юм.

Өнөөх Испани эр маань эх газраас арван нэгэн эр, таван бүсгүйг зэрлэгүүдээс аварч тэр Испаничуудын тав нь арал руу буцаж ирсэн гэнэ. Тиймээс Робинзоныг арал дээр очих үед тэнд ойролцоогоор арван хоёр залуу хүүхдүүд гүйлдэж байсан юм.

Робинзон тэр арал дээр сар орчим байсан бөгөөд тэндхийн хүмүүст зэвсэг, дарь, хувцас болон багаж хэрэгслүүдийг өгчээ. Мөн тэр тэнд хоёр ажилчин үлдээсэн байна – мужаан, дархан хоёр.

Робинзоны хөлөг дараа нь Бразильд газардахад, тэр өөр нэг үхэр, хонь, гахай ачсан хөлөг онгоцыг тэр арал руу илгээсэн байна. Тэр мөн долоон эмэгтэйг зарим залуусын эхнэр болгохоор явуулсан байна.

Дараах жилүүдэд нь Робинзон Баасан хоёр арал дээр хэд хэдэн удаа ирж байсан бөгөөд ирэх бүртээ колончлогчдод олон төрлийн хангамж авч ирж өгдөг байжээ. Гэхдээ шинэ аялал бүр өөрөө адал явдал байдаг, Робинзон Крузогийн амьдралдаа туулсан хамгийн сэтгэл хөдөлгөсөн аялал нь өөрийн арлынхаа захирагчаар нь хорин найман жил суусан тэр адал явдал нь байсан юм.



**ТӨГСӨВ**

**2014 ОН**

**iMobile.mn**

**iMobilemn.blogspot.com**

**Бичсэн: Этка**